



2018

ЖИЛИЙН ТАЙЛАН

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	4
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ	
Төрийн хариуцлагын механизмуудыг бэхжүүлэх	8
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох	17
Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах	19
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих	35
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ	
Хууль сахиулах салбарын шинэтгэлийн дэмжих	
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх	48
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх	
Хүний эрх	
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО	
Тэгш хамруулах боловсрол	64
Залуучуудын дундах үе тэнгийн хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх	72
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	75

ӨМНӨТГӨЛ

Ардчилсан нийгэмд төрийн үйл хэрэг нь ил тод, улс орны хөгжлийн бодлогын асуудлаарх аливаа шийдвэр нь судалгаа тооцоотой, иргэдтэйгээ зөвлөлдсөн, нэгэнт гаргасан хууль журам нь хэрэгждэг, эгэх хариуцлагатай байх аваас сайн засаглал бэхжиж, улс орны тогтвортой хөгжлийн үндэс суурь тавигдах билээ. 2016 оноос хэрэгжиж эхэлсэн чухал хуулиуд иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалахад үр нөлөө бүхий арга, механизмуудыг бий болгосон юм.

Иймээс Нээлттэй Нийгэм Форум нь төрийн хариуцлага, иргэд, иргэний нийгмийн оролцооны шинээр бий болсон боломжуудыг таниулах, тэдгээрийг үр нөлөөтэй ашиглахад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт, үнэлгээ шинжилгээ хийх, үр дүнг судлах олон нийтэд хүргэх зэргээр төрийн бус болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж ирлээ. 2018 онд Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай болон Нийтийн сонсголын тухай хуулиудын талаар иргэний нийгэм, нутгийн удирдлагын байгууллагын 100 гаруй ажилтныг хамарсан сургалтыг Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймагт зохион байгууллаа. Тэрчлэн, 7 байгууллагад нийтийн эрх ашгийн нэн тулгамдсан асуудлаар өмгөөлөл, 10 гаруй аймагт орон нутгийн төсөв болон нийтийн эрх ашиг хөндөгдсөн асуудлаар нийтийн сонсгол хийхэд дэмжлэг үзүүллээ.

Улс төрийн санхүүжилтийг ил тод, оновчтой болгох нь хариуцлагатай төрийг бэхжүүлэх нэн чухал хүчин зүйл болохын хувьд улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, бодлого боловсруулагчид, улс төрийн намуудын төлөөлөл, судлаачдыг хамарсан сургалт семинар, цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж ирлээ. Тухайлбал Ардчилал, Сонгуульд Дэмжлэг үзүүлэх Олон Улсын Хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд судалгаа хийж манай улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоонд нэн тэргүүнд тулгамдаж буй асуудлуудыг тодруулан, холбогдох зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх санал зөвлөмж гаргалаа.

Шилэн дансны хэрэгжилтэд хууль хүчин төгөлдөр болсон эхний өдрөөс эхлэн мониторинг хийж ирсэн иргэний нийгмийн байгууллагууд анх удаа Үндэсний аудитын газартай хамтран төрийн аудит хийхэд оролцон дүнгээ гаргаад байна. Эдгээр байгууллагыг чадавхжуулж мэргэшүүлэхэд ННФ сүүлийн 10 орчим жил хамтран ажиллаж байгаа билээ. Улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт, түүний удирдлагыг сайжруулах, төсвийн ил тод байдлыг сайжруулахад хувь нэмэр болохуйц бие даасан судалгаа шинжилгээг гүйцэтгэж, цуврал хэлэлцүүлгээр олон нийтэд хүргэлээ.

2018 онд Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих чиглэлээр ННФ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд чамлахааргүй ахиц дэвшил гарлаа. Юуны өмнө эрдэс баялгийн салбарын 12 төрлийн 440 орчим гэрээг бүрэн эхээр нь нийтэд ил болголоо (www.iltodgeree.mn). Тэрчлэн салбарын болон хамааралтай 10 гаруй хууль, тогтоомжид өөрчлөлт, шинэчлэлт орсны үр дүнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн сан бий болж, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл нийтэд ил болсон юм. Ийнхүү мэдээлэл ил тод болохын хэрээр түүний бүрэн бүтэн байдал, чанарт хяналт тавих, дүн шинжилгээ хийх, сэтгүүлчдийн эрэн сурвалжлах үйл ажиллагаа чухал юм. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд татвар санхүү, эрх зүй, хөрөнгө оруулалт, байгаль орчин зэрэг асуудлыг хамарсан шинжилгээ хийх чадавх бий болгох талаар анхаарч ажилласны үр дүнд нийтийн эрх ашиг хангагдах боломж орон нутагт сайжирч байна. Дорнод аймгийн Матад, Халхгол сумдад Орон нутгийн гэрээний хэрэгжилтэд нийтийн өмгөөлөл явуулснаар шүүхийн шийдвэр нийтийн эрх ашгийн талд гарч сайн жишиг бий болов.

Эрүүгийн эрх зүй, шүүхийн шинэтгэлийг дэмжих чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Монголын хуульчдын холбоотой тус тус байгуулсан Харилцан ойлголцлын Санамж бичгийн хүрээнд шинээр хэрэгжиж эхэлсэн эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, шууд хамаарах талуудыг оролцуулсан цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 350 гаруй нийтлэг болон тусгай санал боловсруулан ХЗДХЯ-д хүргүүллээ. Дээрх хамтын ажиллагааны хүрээнд шинэ хууль, тогтоомжийг олон нийтэд таниулах, хуульч, хууль сахиулагчдыг чадавхжуулах, хуулиудын тайлбарыг гаргах, хуульчдын дунд цуврал хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг ажил хийгдэх юм. Тэрчлэн 2018

онд цагдаагийн байгууллагад хэрэглэгчийн үнэлгээний арга зүйгээ шинэчлэхэд болон хууль сахиулах салбарт ажиглалт мониторинг хийж туршлагажсан 80 орчим иргэний нийгмийн байгууллагын оролцоотой энэхүү үнэлгээг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсний үр дүнд Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн 2018 оны үнэлгээ чанар сайтай хийгдэж үйл ажиллагаанд тусгалаа олж байна.

Хүний эрхийн хөтөлбөрийн хүрээнд Хүний эрхийн төлөв байдлын дунд хугацааны тайлан бэлтгэх цуврал хэлэлцүүлэгт 21 аймгийн 700 гаруй иргэд, иргэний нийгмийн байгууллага оролцон 10 сар гаруй үргэлжиллээ. Үүний үр дүнд манай улсын хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан 150 зөвлөмжийн 81 хувь нь бүрэн хэрэгжсэн болон хэрэгжих шатандаа, 19 хувь нь огт хэрэгжээгүй байгааг тодорхойлон НҮБ-д тайлангаа хүргүүллээ. Хүний эрхийн форумын сүлжээ нь хүний эрхийн чиглэлээр хяналт тавьж, шаардлагатай үед хамтарсан нөлөөлөл, хамтын үйл ажиллагаа явуулдаг болсноор салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, бие даасан, хөндлөнгийн институт болон бэхжиж байна.

2018 онд шүүхийн шинэтгэлийн үйл явцыг бодитоор үнэлж, оношлох шинэ арга хэрэгсэл болох шүүх эрх мэдлийн индекс боловсруулах төсөл санаачлан шинжээчдийн зөвлөл ажиллуулж арга зүйг боловсруулан 2019 онд туршихаар бэлтгэж байна. Мөн 2017 оноос эхлүүлсэн шүүхийн шийдвэрийн анализын дүн гарч МУИС-ийн ХЗС-тай хамтран зохион байгуулсан цуврал хэлэлцүүлгийн үеэр тодорхой төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн хууль ёсны дүгнэлт, үндэслэл, шүүгчийн хууль хэрэглээний чадвар, мэргэжлийн үйл ажиллагааны талаар өргөн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэв. Ийнхүү хараат бус, бие даасан судалгаа шинжилгээг хөгжүүлэхийн сацуу бодлого боловсруулагчид болон олон нийтэд энэхүү судалгаа шинжилгээний дүнг

өргөнөөр таниулах зорилгоор сэтгүүлч, хуульч, судлаачдын хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

ННФ-ын Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх төслийн хүрээнд хийгдсэн судалгаа, нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд хууль зүйн анхан шатны туслалцааны тогтолцоог бий болгон хэрэгжүүлэх зорилготой “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг МУ-ын Засгийн газар 2018 оны 2-р сард баталлаа. Мөн Нээлттэй Засаглалын түншлэлийн хүрээнд МУ-ын Засгийн газраас хэрэгжүүлэх Үйл ажиллагааны 3-р төлөвлөгөөнд бүх нийтийн эрх зүйн боловсролыг хангах эрх зүйн хөтчийн тогтолцоог хэрэгжүүлэх үүрэг амлалт тусгуулсан нь цаашид хөтөлбөрийн хэрэгжилтэд түлхэц болох томоохон алхам боллоо. Түүнчлэн, хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд хуульчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эхлүүлсэн ажил амжилттай хэрэгжиж хуульчдын нийтэд тустай үйл ажиллагаа идэвхжиж байна. Үүний нэг жишээ нь хуульчид иргэдээс ирүүлсэн асуултад үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх цахим хуудас ажиллаж эхэлсэн явдал юм.

Боловсрол, нийгмийн бодлогын хүрээнд 2018 онд тэгш хамруулах сургах бодлогыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил идэвхтэй өрнөлөө. 2019 оны 9 сараас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд орон нутгийн сургуульд элсэн суралцах нөхцөл бүрдэж, иргэний нийгмийн сүүлийн 10 жилийн бодлогын нөлөөллийн үр дүн гарч эхэллээ. Бид иргэний нийгмийн байгууллагууд бодлогын мөн чанар, түүний хэрэгжилтэд шаардлагатай мэдлэг, мэдээллийг сургууль, багш нарт хүргэхэд дэмжлэг үзүүлж ажиллав. 10 гаруй ТББ-ыг нэгтгэсэн Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ нь бодлогын шүүмж боловсруулж бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдийн дунд хэлэлцүүлэх, тэгш хамруулах боловсролын бодлого, хэрэгжүүлэлтийн үйл явцын талаар сургалт хийх, олон нийтийн дунд дэмжлэг бий

болгох боловсролын үйл ажиллагаа хэрэгжүүлсэн нь олон хүнд хүрч, нэгдсэн ойлголт хандлага бий болгоход хувь нэмрээ орууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо, Монголын Аутизмын холбоо, Даун Синдромын холбоо зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоод, Сонсголгүйн боловсрол ТББ, Түгээмэл хөгжил төв, Хараагүйчүүдийн үндэсний холбоо зэрэг тодорхой хөгжлийн бэрхшээлээр дагнан ажилладаг төрийн бус байгууллагууд 2018 оны туршид хамтран ажиллаж, нийтлэг асуудлаар нэгдсэн төлөвлөгөөгөөр бодлогын нөлөөлөл, олон нийтийн боловсролын үйл ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлэв. ННФ нь иргэний нийгмийн байгууллагуудыг нэгтгэн зангидах үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ агуулга, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллав.

2018 онд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд сургуулийн гүйцэтгэх үүрэг бий болгох тогтолцоог тодорхойлж өгсөн Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого батлагдав. Бодлогыг хэрэгжүүлэх туршлага бий болгох зорилгоор ННФ нь нийслэлийн 10 ЕБС дээр 10 сарын хугацаатай туршилтын төсөл хэрэгжүүлсэн нь амжилттай болж, ирэх хичээлийн жилд бусад сургуульд тараан түгээх мэдлэг, туршлага хуримтлагдав. Эдгээр 10 сургууль нь бусад ЕБС-д туршлагаа дамжуулах төв, манлайлагч болох суурь нь болох юм. ННФ-ын түнш их дээд сургуулиуд ч мөн дотоодын туршлагыг нэгтгэн, тараан түгээх арга хэмжээ хэрэгжүүлэн, дотооддоо шинэ мэдлэг үйлдвэрлэхийн зэрэгцээ Дээрэлхэлтийн эсрэг олон улсын сүлжээ зэрэг гадаадын түншээс олон улсын мэдлэг, туршлагыг дамжуулан ажиллаж байна.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

ТОВЧИЛСОН ҮГ

АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АСТҮОУХ	Ардчилал, Сонгуульд Дэмжлэг Үзүүлэх Олон Улсын Хүрээлэн
БЗМТ	Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БСШУСЯ	Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
ГХЯ	Гадаад хэргийн яам
ДЭЗФ	Дэлхийн эдийн засгийн форум
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУБИС	Монгол Улсын Багшийн Их Сургууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МХХ	Монголын хуульчдын холбоо
МҮОНТВ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ОНХАГ	Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ
ОҮИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ХБХЭЭХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗС	Хууль зүйн сургууль
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ХЭФ	Хүний эрхийн форум
ШУТИС	Шинжлэх Ухаан Техникийн Их Сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УДЭТ	Улсын драмын эрдмийн театр
УИХ	Улсын Их Хурал
УМБГ	Улсын мөрдөн байцаах газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

АРДЧИЛСАН, САЙН ЗАСАГЛАЛЫГ



БЭХЖҮҮЛЭХ



ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ

Хуулиудад тусгалаа олсон оролцооны шинэ механизмуудыг иргэний нийгмийнхэн болон төрийн албан хаагчдад таниулан сурталчлах, хэрэгжилтийг хангахад тэднийг татан оролцуулах зорилгоор Нийтийн сонсголын тухай болон Захиргааны ерөнхий хуулиудыг багтаасан багц сургалтын агуулга боловсруулж, богино видео болгон нийтийн хүртээл болгов.

Ардчилсан сайн засаглалыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд бид төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах гол хуулиудын хэрэгжилтэд анхаарч ажиллах стратеги баримталж байна. Эдгээр хуулийн ихэнх нь УИХ-ын өнгөрсөн ээлжит сонгуулийн өмнөх жил буюу 2015 онд батлагдаж, улмаар сонгуулиар төрийн эрх баригч улс төрийн хүчин солигдсон 2016 оноос хэрэгжилт нь эхэлсэн билээ. Иймд төрийн бодлогын залгамж чанарыг хаа хаанаа хангаж ажиллах нь чухал зүйл байлаа. Энэ хүрээнд шинээр сонгогдсон болон томилогдсон төрийн албан тушаалтнуудад мэдээлэл өгөх, эрх зүйн орчинд гарсан өөрчлөлтийн үр дүнд бий болсон иргэдийн оролцооны шинэ механизмуудыг ашиглах арга барилд иргэний нийгмийн байгууллагуудыг сургаж, хуулийн хэрэгжилтийг хангахад татан оролцуулах ажлыг шат дараатай зохион байгуулж ирлээ.

2018 оны хувьд Нийтийн сонсголын тухай болон Захиргааны ерөнхий хуулиуд, 2016 онд шинэчлэн батлагдсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээг таниулах сургалтыг Баянхонгор, Архангай, Өвөрхангай аймгуудад, мөн Улаанбаатар хотноо дөрвөн удаа зохион байгуулж төр, иргэний нийгмийн төлөөлөл болох 100 гаруй хүнийг хамруулав. Түүнчлэн сургалтын агуулгыг оролцогч талуудад энгийн ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилгоор видео хэлбэрт оруулан интернэтэд байрлуулах ажлыг мөн эхлүүлээд байна. Энэ нь орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хэрэгтэй мэдээллээ олж үзэх, ашиглах боломжийг иргэдэд олгож буй хэрэг юм. Нийтийн сонсгол, тэр нь энгийн хэлэлцүүлгээс юугаараа ялгаатай болох зэрэг түгээмэл асуултуудад хариулт өгсөн эхний видео хичээлийг 4000 орчим хүн үзэж, нийгмийн сүлжээнд 180 хүн бусдад дахин дамжуулжээ. Цаашид нийтийн сонсголын талаар 2-3 видео хичээл бэлтгэж олон нийтийн хүртээл болгохоор төлөвлөөд ажиллаж байна. Ингэснээр иргэдийн оролцооны шинэ тутам механизмын талаар иргэд болон төрийн албан хаагчдын ойлголт нэмэгдэж улмаар шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо нэмэгдэхэд тодорхой хувь нэмэр болно гэж найдаж байна.



ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ

Төрийн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхтэй холбоотой дээрх хуулиудыг практикт хэрэгжүүлэх санаачилгыг идэвхжүүлэх зорилгоор Нийтийн сонсгол, Нийтийн эрх ашгийн өмгөөллийн тэтгэлэгт хөтөлбөрүүдийг жил бүр зарлан, хамрагдсан байгууллагуудад арга зүйн туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж ирлээ. 2018 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сум болон Говь-Алтай, Төв аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-ууд, Дорнод аймгийн Зүүн бүсийн хүний эрхийн төв, Дундговь аймаг дахь Нийгмийн дэвшил дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөний салбар зөвлөл, Өвөрхангай аймгийн Ноёнхайрхан, Оновчтой хөгжил, Сайн засаглал-Тогтвортой хөгжил хүрээлэн ТББ-уудад холбогдох оролцогч талуудтай хамтран нийтийн сонсгол зохион байгуулахад нь тэтгэлэг олгож дэмжлэг үзүүлээ. Өнөөг хүртэл Нийтийн сонсголын тухай хуулийн хүрээнд нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар сонсгол зохион байгуулах туршлага

орон нутгийн түвшинд голлон төвлөрч ирсэн ба УИХ-ын түвшинд иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс удаа дараа хүсэлт илгээн шаардлага тавьж ажиллаж байгаа хэдий ч хуулийг хэрэгжүүлэх идэвх санаачилга хомс байгааг дурдах нь зүйтэй.

Нийтийн эрх ашгийн өмгөөллийн тэтгэлэгт хөтөлбөрт 2018 онд нийт долоон ТББ оролцож тэтгэлэг авчээ. Форумын хувьд 2017 оноос хойш нийт 16 байгууллагад нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх тэтгэлэг олгоод байгаа юм. Түүнчлэн, энэ хугацаанд нийтийн эрх ашгийн өмгөөллийн сургалтыг таван удаа зохион байгуулжээ. 2017 оны 6-р сараас хойших статистикийг үзэхэд Монгол Улсын хэмжээнд нийтийн эрх ашгийн 80 орчим нэхэмжлэл шүүхэд бүртгэгдэж, зарим нь амжилттай шийдэгдээд байгаа аж. ННФ-аас цаашид ч энэ асуудлаарх сургалт, тэтгэлгийн дэмжлэгээ үргэлжлүүлэх стратеги баримтлан ажиллаж байна.



“Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгий өмгөөлөл” сургалт, 2018 оны 6 сарын 7-9. Зүүн гар талаас Өвөрхангай аймагт, баруун гар талаас Баянхонгор аймагт болсон сургалтуудын явц.

Мониторингийн тайлангийн хэсгээс

“Байгууллагууд үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журмаа үйлчлүүлэгчдэд харагдахаар газар байрлуулах” тухай заалтын хэрэгжилтийг судалж үзэхэд төслийн эхний шат хэрэгжсэн 8-р сард 54 хувь нь хангалттай гэсэн үнэлгээ авсан бол эхний шатны үр дүнг олон нийтэд танилцуулсны дараах 10-р сард дахин хяналт тавьж үзэхэд 81 хувь нь хангалттай дүн авч хуулийн дээрх заалтын хэрэгжилт сайжирчээ.

Төслийн хүрээнд “Мэдээлэл бол мэдлэг, Мэдлэг бол хүч” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж тус дүүрэгт оршин суудаг 150 иргэнд хуулийн талаар мэдээлэл өгсөн ба тэднээс төрийн байгууллагаас мэдээлэл авах шаардлагатай иргэдийг тодруулан төрийн дөрвөн байгууллагад хандан хүсэлт гаргасан. Ингэхэд төрийн үйлчилгээний нэг байгууллага тодорхойгүй шалтгаанаар мэдээлэл өгөхөөс татгалзсан.

Иргэдийн оролцоотой холбоотой дээрх хуулиудаас гадна иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад томоохон дэвшил болж 2011 онд батлагдсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд мөн анхааран ажиллаж ирлээ. Иргэдийн мэдэх эрхээс гадна төрийн үйлчилгээний чиглэлээр ажиглалт, мониторинг хийдэг төрийн бус байгууллагуудын хувьд дээрх хууль нь тэдний гол хэрэгсэл болдог. 2018 оны хувьд Багануур дүүргийн хэмжээнд хуулийн хэрэгжилтэд мониторинг хийхэд нь Залуус манлайлал ТББ-д дэмжлэг үзүүлэв. Багануур дүүрэгт төрийн захиргааны 14, төрийн үйлчилгээний 18 байгууллага байдгаас дүүргийн ЗДТГ, Газрын алба тэргүүтэй 13 байгууллагыг хамруулан хоёр үе шаттайгаар төслийг хэрэгжүүлжээ. Мониторингийн хүрээнд нэг талаас төрийн байгууллагууд иргэдэд байнга ил байлгах ёстой мэдээлэл, нөгөө талаас иргэд мэдээлэл авахаар хүсэлт гаргахад хуулийн дагуу хариу өгөх байдалд тус тус хяналт тавьсан байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Шилэн дансны тухай хууль, Улсын бүртгэлийн тухай багц хуулийн шинэчлэл гэх мэт мэдээллийн ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн хэд хэдэн чухал хууль батлагдан хэрэгжиж эхэлсэн. Үүний үр дүнд төрийн төсөв санхүү, чухал гэрээ хэлэлцээр, үйл ажиллагааны талаарх нээлттэй өгөгдөл, мэдээлэл нэмэгдэж ирсэн. Энэ хэрээр сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагууд болон идэвхтэй иргэдийн зүгээс хяналт тавих, зөрчилтэй асуудал ажиглагдвал мэдээлэх давтамж, идэвх өсөх хандлагатай байна. Ялангуяа эрэн сурвалжилга хийж буй сэтгүүлчдэд мэргэжлийн болон хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэрчлэн мэргэжил нэгт нөхөд болон олон нийтийн дэмжлэгт үндэслэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чанар, үр нөлөөг дээшлүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Нөгөө талаас, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах нь мөн анхаарах асуудал юм. Иймээс эрэн сурвалжлах сэтгүүлчдэд дэмжлэг үзүүлэх байнгын үр нөлөөтэй арга механизмыг бий болгож төлөвшүүлэх нь хойшлуулшгүй чухал асуудал болоод байна.



ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ

Тэрчлэн, мэдээллийн эрин үед нийгмийн сүлжээний гүйцэтгэж буй үүрэг уламжлалт хэвлэл мэдээлэлтэй өрсөлдөх хэмжээнд хүрч үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл шуурхай авах болон түгээх нэн нөлөөтэй хэрэгсэл нэгэнт болжээ. Гэвч нөгөө талаас, нийгмийн сүлжээ нь худал мэдээлэл тараах, үзэн ядалт, ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлэх зэрэг сөрөг үзэгдлийн талбар бас болж байна. Эдгээр үзэгдэлтэй зэрэгцэн төрийн зүгээс нийгмийн сүлжээг хэтрүүлэн зохицуулах оролдлого, санал санаачилгууд мөн гарч эхэллээ. Энэхүү нөхцөл байдалд иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах, ингэхдээ хувь хүний халдашгүй байдлыг хамгаалахад чиглэсэн зохистой эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийгмийн сүлжээнд ёс зүйтэй оролцох, худал мэдээллийг таних арга хэрэгслүүдийг олон нийтэд таниулах зэрэг үйл ажиллагаа чухал байна. Энэхүү үүсээд буй нөхцөл байдлыг үндэслэн ННФ-ын зүгээс 2018 онд “Глоб интернэшнл төв” ТББ-д тэтгэлэг олгон хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд өнөөг хүртэл хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн асуудлаар мэргэшсэн хуульч ажиллан хууль зүйн туслалцаа шаардлагатай байгаа сэтгүүлчдэд зөвлөгөө дэмжлэг үзүүлж байна. Үүний зэрэгцээ хуурамч мэдээлэл, нийгмийн сүлжээний зохистой зохицуулалтын талаар судалгаа хийхээр ажиллаж байна.

Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг цаашид лавшруулан сайжруулахад шаардлагатай судалгаа шинжилгээ хийж гүйцэтгэхэд бие даасан судлаачидтай хамтран ажиллахын

зэрэгцээ тулгамдсан тодорхой асуудлуудаар цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж ирэв. 2018 оны тухайд Захиргааны ерөнхий хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн иргэдийн эрх ашигт нөлөөлөх байдал, Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн аудитын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төсөл, Төрийн аудит ба иргэдийн оролцоо зэрэг асуудлаар хэлэлцүүлгүүд зохион байгуулсны зэрэгцээ “Төрийн өндөр албан тушаалтнуудын халдашгүй байдлын цар хүрээ, алба хашиж байх үед нь хянан шалгаж, хариуцлага тооцох боломж”, “Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлын эрх зүйн орчин” сэдвүүдээр судалгаа хийж буй бие даасан судлаачдад дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллалаа.

Монгол Улсад ардчиллыг хөгжүүлэн бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, нийтийн эрх ашгийг хамгаалах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн иргэний нийгмийн байгууллагуудын хөгжлийг дэмжих, үйл ажиллагаагаа тогтвортой, үр дүнтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх зорилгын хүрээнд тодорхой ажлуудыг мөн зохион байгуулж ирлээ. Энэ чиглэлд 2018 онд “Төрийн бус байгууллагын санхүүгийн менежментийн суурь ойлголт” сэдэвт сургалтыг шинэчилсэн агуулгаар зохион байгуулсан ба нийт 50 ТББ-д санхүүгийн программ хангамж олгон, ашиглах арга барилд суралцахад нь дэмжлэг үзүүлэн шат дараатай сургалт зохион байгууллаа.



АРДЧИЛСАН, САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ: 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

9 УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- “Захиргааны ерөнхий хуульд оруулах нэмэлт өөрчлөлт иргэдийн эрх ашигт нөлөөлөх нь” сэдвээр 7 сарын 6-д сэтгүүлчдийн өргөтгөсөн уулзалт хийж хуульч Р.Мөнхзул, Билэгсайхан, иргэн Л.Алтанцэцэг нар гол чиглүүлэгчээр оролцов.
- “Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сургалт, 4 сарын 26-27
- “Төрийн албаны тогтвортой байдал ба улс төр” өглөөний-хэлэлцүүлэг 4 удаа, 3 сарын 28-29, 10 сарын 19, 10 сарын 24
- “Сонгуулийн санхүүжилтийн ил тод байдал, хариуцлага” хэлэлцүүлэг, 9 сарын 28
- “Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал” хэлэлцүүлэг, 11 сарын 07
- “Төрийн аудит ба иргэний нийгмийн оролцоо” хэлэлцүүлэг, 11 сарын 27

6+ СУРГАЛТ, БУСАД АРГА ХЭМЖЭЭ

- Нийтийн сонгол зохион байгуулах сургалт, 3 сарын 28-29
- “Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл” цуврал сургалт Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймагт 6 сарын 04-12-ны хооронд зохион байгуулагдаж төвийн аймгуудын иргэний нийгмийн төлөөлөл оролцов.
- “Төрийн бус байгууллагын санхүүгийн менежментийн суурь ойлголт өгөх сургалт, 9 сарын 27
- “Захиргааны Ерөнхий Хууль, Нийтийн Сонголын тухай хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэний нийгмийн төлөөлөлд мэдээлэл өгөх” уулзалт – сургалт, 10 сарын 19



“Нийтийн сонгол” сургалт 2018 оны 3 сарын 28. ННФ . Аласкийн Их сургуулийн профессор Жон Даффи

ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ: 2018 ОНД ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН

НИЙТИЙН СОНГОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
СХМ-ДЭХЭЭ

НИЙТИЙН СОНГОЛ
ТӨРИЙН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМУУДЫГ БЭХЖҮҮЛЭХ

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

СОНГОЛ ХӨРӨӨНӨН	НИЙТИЙН СОНГОЛ	СХМ-ДИЙН СОНГОЛ
Хүний нэгдэл, төлөөлөгчид хуульчилсан байдал эс үзвэл нийтийн сонголд оролцоход хүчингүй болно.	Хүний нэгдэл, төлөөлөгчид хуульчилсан байдал эс үзвэл нийтийн сонголд оролцоход хүчингүй болно.	Хүний нэгдэл, төлөөлөгчид хуульчилсан байдал эс үзвэл нийтийн сонголд оролцоход хүчингүй болно.
Хүний нэгдэл, төлөөлөгчид хуульчилсан байдал эс үзвэл нийтийн сонголд оролцоход хүчингүй болно.	Хүний нэгдэл, төлөөлөгчид хуульчилсан байдал эс үзвэл нийтийн сонголд оролцоход хүчингүй болно.	Хүний нэгдэл, төлөөлөгчид хуульчилсан байдал эс үзвэл нийтийн сонголд оролцоход хүчингүй болно.

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА


НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА

НИЙТИЙН СОНГОЛ
НИЙТИЙН СОНГОЛД АСУУГУУДЫН ХАРИУГА



ОНЛАЙН ХИЧЭЭЛ:



- Нийтийн сонголын талаарх видео хичээл - 1
<https://www.youtube.com/watch?v=X8Y2hhoGlio>

- Томилгооны сонголын тухай видео хичээл - 2
<https://www.youtube.com/watch?v=AAGw0WzIfTI>



СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦ, УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Нийт сонгогчдын 50-иас доошгүй хувийн ирц бүрдсэнээр тойргийн сонгуулийн дүнг хүчинтэйд тооцох; нэрийн жагсаалтыг сонгуулийн жил эхлэхэд шинэчилж, давхардлыг арилгасны дараа тойрог хэсгээр хуваах, цахим жагсаалтад өөрчлөлт оруулахыг хязгаалах, иргэд хянах боломжийг хуульд заах; сонгуулийн санхүүжилтийг ил тод болгох асуудлыг хуульд тодорхой тусгах ...

“Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээнээс УИХ-ын ТББХ-нд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан хүргүүлсэн Зөвлөмжөөс

2018 оны хувьд 2020 оны УИХ-ын ээлжит сонгууль ойртохоос урьтаж сонгуулийн хууль тогтоомжийг сайжруулан шинэчлэх, оролцогч талуудаас санал авч тусгах ажил нэлээд урагшилж улмаар сонгуулийн холбогдолтой хуулиудын төслийг УИХ-д өргөн барьсан чухал жил байв. ННФ-ын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран өмнөх сонгуулиудад ажиглалт хийсэн туршлагадаа үндэслэн сонгуулийн процессыг цаашид сайжруулахад авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай арга хэмжээг Зөвлөмж хэлбэрээр Сонгуулийн тухай хуулийг шинэчлэх дэд ажлын хэсэгт хүргүүллээ. Тэрчлэн, сонгогчдын нэрийн жагсаалтын хяналт гэх зэрэг тодорхой сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлж оролцогч талуудыг мэдээллээр хангахад анхаарч ажиллалаа.

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо (ТББХ)-нд УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөлтэй холбоотой хэд хэдэн тодорхой саналыг ННФ-ын санаачилгаар байгуулагдсан “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүд хамтран хүргүүлсний дотор дараах саналууд багтжээ.

“Оролцоонд суурилсан улс төр: саад бэрхшээл, шийдвэрлэх арга зам” сургалт семинар, 2018 оны 6 сарын 9. ННФ



- ▶ Монгол Улсад ардчилсан сонгуулийн хүлээн зөвшөөрөгдөх (легитимит) чанарыг баталгаажуулж ирсэн нэг гол зохицуулалт нь сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн тавиас доошгүй хувийн ирц бүрдсэнээр тойргийн сонгуулийн дүнг хүчинтэйд тооцох шаардлага юм. Гэтэл УИХ-ын сонгуулийн хуулийн шинэ төсөлд дээрх зохицуулалт орхигдсон байна.
- ▶ Сонгогчийн нэрийн жагсаалтыг сонгуулийн жил эхлэхэд нэгдсэн байдлаар заавал шинэчлэн гаргаж давхардлыг шалгаж арилгасны дараа тойрог, хэсгээр хуваах, нэрийн цахим жагсаалтад даамлын зүгээс өөрчлөлт оруулах боломжийг хязгаарлахын зэрэгцээ иргэд хяналт тавих боломжтой байх процессыг хуульд тодорхой заах нь зүйтэй гэж үзэж байна. Сүүлийн сонгуулиудаар сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гарч буй гомдол, маргааны дийлэнх нь иргэдийн удаан хугацаагаар оршин суусан хаяг дээр огт байхгүй олон тооны сонгогчийг бүртгэсэн тухай гомдол байх тул энэ асуудлыг нэг мөр цэгцлэх шаардлагатай юм. Одоогийн төслийг үзэхэд эл асуудлыг шийдвэрлэхдээ нэрийн жагсаалтаас сонгогч зөвхөн өөрт холбогдолтой мэдээллийг шалгахаар заасан байгаа нь хэтэрхий явцуу шийдэл байх бөгөөд асуудлын голыг олохгүй бол сонгуулийн үйл явц, үр дүнд итгэх иргэдийн итгэлд сөргөөр нөлөөлөх эрсдэл буйг анхааруулах нь зүйтэй.
- ▶ Сонгуулийн санхүүжилттэй холбоотой мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг хуульд тодорхой тусган шийдвэрлэх нь зүйтэй. Үүнд нам, эвслийн зардлын дансанд хуримтлагдсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр, нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдээллийг санал хураах өдрөөс өмнө цахим хуудсанд байршуулж ил болгох, сонгууль дуусмагц зардлын тайланг цаг алдалгүй ил тод болгосны дараа төрийн аудитын байгууллага нь гүнзгийрүүлсэн хяналт тавьдаг бусад улсын туршлагыг нэвтрүүлэх нь чухал ахиц болно.





АРДЧИЛСАН, САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

ННФ 2014 оноос эхлэн улс төрийн санхүүжилтийн асуудлыг бие даасан судлаачид, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран олон талаас нь судалж, мониторинг хийн олон улсын туршлага, баримт нотолгоо, судалгаа шинжилгээнд үндэслэсэн чанартай мэдээллээр оролцогч талуудыг хангах замаар эрх зүйн орчны шинэчлэлд хувь нэмрээ оруулж ирлээ. 2018 оноос эхлэн Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр Ардчилал, Сонгуульд Дэмжлэг Үзүүлэх Олон Улсын Хүрээлэн (АСДҮОУХ)-тэй хамтран “Улс төрийн санхүүжилт: Ёс зүй, оролцоо, хариуцлага” төслийг хэрэгжүүлж эхэллээ. Уг төслийн хүрээнд олон улсын судлаачидтай хамтран “Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин: Дүн шинжилгээ санал зөвлөмж” судалгааг хийж олон нийтийн хүртээл болгов. Уг судалгаанд Монгол Улс дахь сонгууль, улс төрийн намын санхүүжилтийн тогтолцоонд нэн түрүүнд тулгамдаж байгаа, зайлшгүй анхаарах шаардлагатай асуудлууд болон тэдгээрийг олон улсын стандартад нийцүүлэн хэрхэн засаж залруулах талаар тодорхой саналуудыг тусгаж тайлбарлажээ.

Улс төрийн санхүүжилтийн тогтолцоог шинэчлэхэд оролцогч талуудын дунд, ялангуяа улс төрийн намуудын дунд зөвшилцөл бий болох нь чухал юм. Үүнтэй холбоотой АСДҮОУХ-тэй хамтран хэрэгжүүлж буй дээрх төслийн хүрээнд улс төрийн санхүүжилтийн тогтолцоог өөрчлөхөд чухал гэж үзсэн тодорхой асуудлуудаар намуудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгүүдийг байнга зохион байгуулж, мэдээллээр хангах, нөгөө талаар тэдний байр суурийг сонсон, санал солилцох боломж олгох ажлыг шат дараатай хийж байна. 2018 онд намуудад олгох төрийн санхүүжилт, түүнд тавих шалгуур, намын дотоод ардчилал, хариуцлага, ил тод байдал, хяналт зэрэг сэдвүүдээр олон улсын нэр хүндтэй байгууллагын туршлагатай

мэргэжилтнүүдтэй хамтран таван удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан нь дээрх асуудлуудаар намуудын дунд нэгдмэл ойлголт бий болоход тодорхой хэмжээгээр нөлөөллөө гэж үзэж байна. Эхний хэлэлцүүлгүүдийн үеэр намынхны зүгээс Монголын улс төрийн намуудад тулгамдаж буй нийтлэг асуудлууд, шийдлийн талаар өрсөлдөгч намынхаа төлөөлөлтэй зэрэгцэн сууж санал солилцоход үл итгэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, хуваалцахаас цааргалах байдал ажиглагдаж байсан бол сүүлийн хэлэлцүүлгүүдээр санал бодлоо чөлөөтэй солилцон улмаар Сонгуулийн тухай болон Улс төрийн намын тухай хуулиудад зориулсан Зөвлөмж хамтран боловсруулснаар 2018 оныг өндөрлөн 2019 онтой золголоо. Түүнчлэн, 2020 оны сонгуулийг угтан улс төрийн санхүүжилтийн цахим тайлангийн систем, эрх зүйн орчны шийдлийн олон улсын туршлагад суурилсан загварчлал зэрэг сэдвээр АСДҮОУХ-гийн мэргэжилтнүүдтэй хамтран сургалт, хэлэлцүүлгүүд зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Улс төрийн намуудтай ийнхүү ажиллахаас гадна иргэний нийгэм, олон нийтийг мэдээллээр хангах нь мөн чухал болохыг үйл ажиллагааны стратегидаа онцолсны дагуу сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. ННФ-тай сонгууль, улс төрийн санхүүжилтээр ажилладаг төрийн бус байгууллагуудын хувьд чадавх нь харьцангуй сайн, үйл ажиллагаа нь тогтмолжиж танигдсан байгууллагууд байдаг давуу талтай. Энэ хүч бололцоог сааруулахгүй байх үүднээс ойрын жилүүдэд залуучуудын байгууллагуудыг татан оролцуулж, чадавхыг нь бэхжүүлэн хамтран ажиллах тактикийг баримталж байгаа болно. Тухайлбал, 2018 онд бид анх удаа байгууллагын үйл ажиллагааг дэмжих уян хатан тэтгэлгийг “Бодлогод залуусын хяналт” ТББ-д олгов.

СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦ, УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Тус байгууллага нь “Улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг дээшлүүлэхэд нөлөөлөх” зорилго бүхий урт хугацааны хөтөлбөртэй болоход тэтгэлгийг ашигласан ба 2018 онд гол зорилтот бүлэг болох залуучуудад улс төр дэх хяналтгүй мөнгөний хор уршгийг таниулах, тодорхой шийдлүүдийг танилцуулах зорилгоор мэтгэлцээн, бодлогын хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний бага хурал зэрэг арга хэмжээг шат дараатай зохион байгуулж 282 оюутан, сайн дурынхныг татан оролцуулжээ. Үүнээс гадна нийгмийн сүлжээгээр зохион байгуулсан мэдээллийн аян, дамжуулсан видео болон шууд/лайв мэдээллийг хүлээн авч, идэвхтэй үзэж танилцсан хандалтын тоо 53056 (нийт 19 видео болон шууд дамжуулалтыг хүлээн авч үзсэн идэвхтэй хандалтын тоо) –д хүрсэн байна. Уг тэтгэлэгт үндэслэн www.policywatch.mn вэб сайтыг хөгжүүлж эхэлсэн байх ба сүүлийн жилүүдэд улс төрийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, цуглуулсан мэдээллийг байршуулж, улс төрийн санхүүжилтийн асуудлаар мэдээлэл хайж, судалж буй залууст эх сурвалж болгохоор ажиллаж байна.

Олон нийтэд мэдээлэл хүргэх хүрээнд 2014 оноос хамтран ажиллаж буй сэтгүүлчдийн клубийн гишүүд 2018 онд 40 орчим мэдээ, нийтлэл бэлтгэн өөрсдийн ажилладаг мэдээллийн сувгуудаараа цацахын сацуу www.shilennam.mn цахим хуудсанд байрлуулжээ.

Улс төрийн санхүүжилтэд хяналт тавих гол байгууллага нь төрийн аудитын байгууллага бөгөөд Форумын зүгээс 2018 оны 10-р сард Төрийн аудитын байгууллагатай хоёр жилийн хугацаанд хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурахдаа хамтын ажиллагааны нэг асуудал нь улс төрийн санхүүжилтийн хяналт байна гэж тусгасан. Энэ хүрээнд 2018 онд улс төрийн санхүүжилтийн асуудлаар бусад улсын туршлагатай танилцаж мэдээлэл авах бололцоогоор хангахад анхаарч ажилласан ба 2019 онд улс төрийн нам, нэр дэвшигчдийн тайлан гаргах маягт, тэдгээрт тавигдах шаардлага, гарын авлага зэргийг боловсруулах, цаашлаад цахим тайлангийн системийг боловсруулах асуудлаар лавшруулан ажиллана.

“Улс төрийн санхүүжилт ба жендэр; Улс төрийн санхүүжилт ба улс төрийн үйл явц дахь залуучуудын оролцоо” сургалт 2018 оны 6 сарын 18-22. ННФ



СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦ, УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ: 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН

10 УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ;

- “Улс төр-Сэтгүүлчдийн клуб”-ийн гишүүдийн уулзалт - 6 удаа
- “Улс төрийн санхүүжилт: Ёс зүй оролцоо, хариуцлага” төслийн нээлтийн арга хэмжээ, 5 сарын 09
- “Улс төрийн санхүүжилт хяналт, хариуцлага - Гүрж Улсын туршлага солилцох уулзалт, 7 сарын 03
- “Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин” судалгааны тайлан, сургалт, хэлэлцүүлэг, 11 сарын 28-29
- “Сонгогчдын нэрийн жагсаалт, хяналт” хэлэлцүүлэг, 6 сарын 1

5 СУРГАЛТ, БУСАД АРГА ХЭМЖЭЭ

- “Улс төрийн санхүүжилт ба жендер” семинар, 6 сарын 18-19
- “Улс төрийн санхүүжилт ба улс төрийн санхүүжилтийн үйл явц дахь залуучуудын оролцоо” семинар, 6 сарын 21-22
- “Улс төрийн санхүүжилтэд тавих хяналт” сэдэвт олон улсын бага хуралд оролцох аялал, Гүрж Улсын Тбилиси хотод, 6 сарын 25-27 Үндэсний аудитын газрын төлөөлөл, бие даасан судлаач нар оролцов.
- “Оролцоонд суурилсан улс төр: саад бэрхшээл, шийдвэрлэх арга зам” сургалт-хэлэлцүүлэг, 9 сарын 6-7
- “Улс төрийн нам, улс төрийн санхүүжилтийн асуудлаар Канад Улсын туршлага судлах” аялал, Канад Улсын Оттава хотод, 11 сарын 19-22 Үндэсний аудитын газрын төлөөлөл, УИХ-ын Улс төрийн намын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүд оролцов.

“МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Монгол Улсын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчинд тулгамдаж буй гол сорилт нь хуулийн хийдэл их, байгаа хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа явдал. Тиймээс юуны өмнө эрх зүйн орчны шинэчлэл яаралтай хийх шаардлагатай.





ТӨСВИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ

Төсвийн
удирдлагыг тууштай
сайжруулахгүйгээр,
ялангуяа хөрөнгө
оруулалтын болон тусгай
сангуудын удирдлагыг
шинэ түвшинд авч
үзэхгүйгээр төсвийн
алдагдал, өрийн
асуудлыг шийдэхэд бэрх
юм.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын төсөв алдагдалтай батлагдах нь хэвийн шахуу үзэгдэл болсны зэрэгцээ улсын нийт өрийн хэмжээ эрс өсөж байгаа нь санаа зовоосон асуудлын нэг болж байна. Нээлттэй Нийгэм Форумын зүгээс жил бүр улс, орон нутгийн төсвийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн ил тод байдал зэрэг тодорхой асуудлуудаар судалгаа шинжилгээ хийж, үр дүнгээр бодлого боловсруулагчид, иргэний нийгмийн оролцоотойгоор өргөн хүрээний цуврал хэлэлцүүлэг өрнүүлэх, хялбаршуулсан мэдээллийн багц, инфографик гаргах зэргээр тогтмол нөлөөллийн ажлууд хийж ирлээ. Дээр дурдсан бүх үйл ажиллагаагаар төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг хангахад чиглэсэн хууль, журмуудын хэрэгжилт үндэсний хэмжээнд ямар байгааг тодорхой хүрээнд дүгнэж цэгнэх, бодитой мэдээллийг бодлогын түвшинд хүргэх, төрийн хяналтын байгууллагуудтай үр дүнтэй хамтын ажиллагаа өрнүүлснээр төсвийн үйл явцад иргэд, иргэний нийгмийн оролцоог бий болгохыг зорилоо. 2018 оноос бид төсөв дэх иргэдийн оролцооны шинэ механизм болох Төсвийн хяналтын сонсголыг орон нутагт хэрэгжүүлэх чиглэлээр мөн ажиллав.

Улс, орон нутгийн төсөв ба түүний удирдлагыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа

Батлагдахаас өмнө улсын төсвийн мэдээллийг хялбаршуулан олон нийтэд түгээх, төсвийн үйл явцад тэднийг оролцуулах зэргээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулах нь төсвийн төлөвлөлтийг сайжруулахад чухал ач холбогдолтой болохыг олон улсын байгууллагуудаас зөвлөмж болгодог. Сүүлийн арав гаруй жилийн туршид ННФ Монгол Улсын төсвийн бодлого, төлөвлөлт болон тухайн цаг үед тулгамдаж буй асуудлаар бусад байгууллага, судлаачидтай хамтран судалгаа шинжилгээ хийн дүн, мэдээллийг бодлого боловсруулагч, олон нийтэд хүргэсээр ирсэн. 2018 онд бид Монгол Улсын 2019 оны төсвийн орлогыг бүрдүүлэх гол эх үүсвэрүүд, нөгөө талаас бодлогын тулгамдсан асуудалд зарцуулах хөрөнгийг нарийвчлан шинжлэхийг зорьсон юм. Уг судалгаагаар татварын болон эрдэс баялгийн салбараас төвлөрүүлэх орлогын төлөвлөлт, улсын төсвийн хөрөнгө оруулалт, Нийгмийн даатгалын сангийн зарлагын төлөвлөлт, Улаанбаатар хотын агаарын бохирдолд зарцуулах төсөв зэргийг тусгайлан сонгож дүн шинжилгээ хийлээ. Судлаачид, төрийн бус

АРДЧИЛСАН, САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ



“Монгол Улсын 2019 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт”
сэдэвт уулзалт, хэлэлцүүлгүүдийн үеэр (2018 оны 10-р сар)

байгууллагын төлөөлөл судалгааныхаа үр дүнг цуврал хэлэлцүүлгээр олон нийтэд танилцуулав (Энэ сэдвийн “2018 онд зохион байгуулсан үйл ажиллагаа” хэсгийг харна уу).

Цуврал хэлэлцүүлэгт Сангийн яам, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл зэрэг төрийн байгууллагын төлөөлөл оролцож, 2019 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөлт, санал, дүгнэлтээ оролцогчдод танилцуулсныг тэмдэглүүштэй. Тэрчлэн, Сангийн яамнаас 2018 оны батлагдсан төсвийн, 2019 оны төсвийн төсөл болон батлагдсан төсвийн иргэнд зориулсан хялбаршуулсан хувилбаруудыг гаргасан нь урд өмнө байгаагүй дэвшил байв. Энэ нь ННФ 2006 оноос “Төсвийн нээлттэй байдал” үнэлгээн дэх Монгол Улсын судалгааг хийж, үр дүнг бодлого боловсруулагчид, олон нийтийн анхааралд оруулж ажилласны үр дүн гэж бид харж байна. Энэхүү судалгааг АНУ-д төвтэй Олон улсын төсвийн түншлэл (www.internationalbudget.org) байгууллагаас хийж, дэлхийн 100 гаруй орны төсвийн ил тод байдал, төрийн хяналтын байгууллагуудаас төсөвт тавих хяналт, төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог 2 жил тутамд үнэлдэг юм. “Төсвийн нээлттэй байдал”

үнэлгээнээс харахад, манай улсын төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоо нэн хангалтгүй байгаа тул Засгийн газраас дээр дурдсан иргэний төсвийг тогтмол гарган, цаашид иргэдийн оролцоог сайжруулахад анхаарч ажиллах хэрэгтэй юм.

Монгол Улсын төсөв 2019 онд ч алдагдалтай байх ба төсвийн зарлага нь анх удаа 10 их наядаас давж өмнөх оныхоос 2 их наядаар өсөхөөр төлөвлөгдөв. Мөн улсын нийт өр 2018 оны эцсийн байдлаар 22 их наяд төгрөгт хүрсэн байгаа нь өрийн дарамт үүсгэх хэмжээнд байгаа юм. Тиймээс төсвийн удирдлагыг сайжруулах, ялангуяа хөрөнгө оруулалтын болон тусгай сангуудын удирдлагад илүүтэй анхаарах шаардлагатай байна. Иймээс бид 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд анхаарах асуудлуудыг дээр дурдсан хэлэлцүүлгүүдээрээ хөндөж, төсвийг энгийн ойлгомжтой харуулсан цуврал инфографик гарган нийтэд хүргэв.

ННФ-ын зүгээс төсвийн хүрээнд сүүлийн жилүүдэд тогтмол хийж байгаа ажлын нэг нь орон нутгийн төсвийн ил тод байдалд ажиглалт мониторинг, судалгаа шинжилгээ хийн үр дүнг иргэний нийгмийнхэн болон төрийн байгууллагын



ТӨСВИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ



“Монгол Улсын 2019 оны төсвийн орлогын төлөвлөлт” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийн үеэр (2018 оны 10-р сар)

төлөөллүүдэд танилцуулж байгаа явдал. Энэ чиглэлээр иргэний нийгмийн ажилтнуудыг чадавхжуулан тэдгээр байгууллага нь орон нутагт идэвх зүтгэлтэй ажиллан зарим үр дүнд хүрч байгаа нь сайшаалтай. 2018 онд төсвийн байгууллагуудын ил болгосон худалдан авалт, гүйлгээний мэдээлэлд иргэний нийгмийнхэн ажиглалт хийн төсвийн зарцуулалтыг хянах, түүнд орон нутгийн иргэдийг оролцуулах, төсвийн сонсгол зохион байгуулах зэргээр бидэнтэй хамтран ажиллав. ННФ 15 аймаг, нийслэлд ажилласан 19 төрийн бус байгууллагын төслийг санхүүжүүлж, нэгдсэн арга зүйгээр хангаснаар эдгээр байгууллага төсвийн зарлага, худалдан авалт, Засаг даргын нөөц сан, Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт зэрэгт мониторинг хийж, төсвийн зарцуулалтыг хянахад нутгийн иргэдийг оролцуулах, төсвийн мэдээллийг



Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан төсвийн хяналтын сонсголын явцаас

орон нутгийн иргэдэд хүргэх зэргээр үр дүнтэй ажиллалаа. Тэрчлэн, Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Говьсүмбэр, Орхон зэрэг 9 аймагт төсвийн хяналтын сонсгол зохион байгуулагдав. Эдгээр үйл ажиллагаа нь цаашид төсвийн үйл явц дахь иргэдийн идэвх оролцоог өрнүүлэх, төсвийн хяналтын сонсгол тогтмолжих, төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулна гэж бид үзэж буй.

Цаашид бид иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс төсвийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжихээс гадна төрийн аудитын байгууллагаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулахад анхаарч ажиллах юм.



АРДЧИЛСАН, САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

Төрийн ба төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа


Төсвийн ил тод байдлыг зохих түвшинд хүртэл сайжруулахад иргэний нийгмийн зүгээс сүүлийн жилүүдэд хийж гүйцэтгэж байгаа шилэн дансны мониторинг, тэдний орон нутагтаа явуулж буй нөлөөллийн ажил зэрэг нь тодорхой хэмжээнд амжилт олж байгаа хэдий ч төрийн мэргэжлийн байгууллагатай үр дүнтэй хамтран ажиллаж чадвал илүү үр дүнд хүрэх нь тодорхой. Энэ үүднээс ННФ 2018 онд Үндэсний Аудитын газартай хамтын ажиллагаа тогтоох эхлэлийг тавьж 10 дугаар сард хамтран ажиллах Санамж бичиг байгууллаа.


Санамж бичгийн хүрээнд бид Монгол Улсад төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах, төрийн хяналтыг хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих зэрэг чиглэлд ажиллах юм. Төрийн аудитын байгууллага болон иргэний нийгэм нягт хамтран ажилласнаар төсвийн ил тод, хариуцлагатай байдалд ихээхэн

ахиц гарах боломжтой юм. Иргэд сонгосон төрөө хариуцлагатай байлгах боломж, нөхцөлийг бүрдүүлэх явдлыг дэмжих нь сүүлийн үед аудитын байгууллагын үйл ажиллагааны нэг чиглэл болоод байна. Энэ утгаараа олон улсад төрийн аудитын зүгээс иргэний нийгмийн байгууллага, идэвхтэй иргэдтэй хамтран ажиллах явдал өргөжиж, олон сайн туршлага бий болж, сайн засаглалыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Монгол Улсын Үндэсний Аудитын газар ч энэ чиглэлээр тодорхой санаачилга гаргаж Иргэний танхим байгуулан ажиллуулж эхэлснийг тэмдэглүүштэй.

Дээрх Санамж бичгийн хүрээнд эхэлсэн нэг чухал ажил нь Шилэн дансны тухай хууль дахь "... төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд ... 10 сая төгрөгөөс дээш

Нээлттэй Нийгэм Форумас Үндэсний аудитын газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулах үеэр (2018 оны 10-р сар)





ТӨСВИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ

үнийн дүн бүхий ажил, үйлчилгээний санхүүжилт, хэрэгжилтийн явцаа шилэн дансны цахим хуудаст мэдээлэх” үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгааг хянах төрийн аудитад анх удаа иргэний нийгмийн шинжээчид оролцсон явдал юм. Энэ нь Төрийн аудитын байгууллага болон иргэд, олон нийт, төрийн бус байгууллага хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох эхний ажил болж байгаагаараа онцлогтой юм.

Бид 2015-2017 онуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад иргэний нийгмийн хүчин чармайлтыг хандуулан орон даяар нэгдсэн арга зүй, зохион байгуулалтын дор мониторинг хийж, дүнг нэгтгэн үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд олон нийтэд хүргэж байсан нь уг хууль хэрэгжихэд чухал түлхэц үзүүлсэн. Энэхүү ажлын туршлага нь төрийн аудитад анх удаа иргэний нийгмийн байгууллагууд хамтрах үндэс суурь болсон гэж үзэж буй.

Иргэний нийгмийн зүгээс хийсэн дээрх ажиглалтын дүнд төсвийн байгууллагууд шилэн дансны

мэдээллээ нийтлэх байдал харьцангуй нэмэгдэж байгаа нь харагдсан. Гэсэн хэдий ч Хуулийн 6.9 дэх заалтын дагуу төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэж буй аж ахуйн нэгж, байгууллагууд төслийн мэдээллээ ховорхон нийтэлж байгаа нь ажиглагдсан юм. Энэ удаагийн төрийн аудитад улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд болох сургууль, цэцэрлэг, өрхийн эмнэлгүүд хуульд заасан мэдээллийг хэрхэн нийтэлснийг иргэний нийгмийн зүгээс шалгав (Аудитын дүнг ирэх онд Үндэсний аудитын газраас УИХ-д танилцуулна). Ийнхүү төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдийн мэдээллийг ил болгон, зохих нөлөөллийн үйл ажиллагаа явуулах нь төсвийн хөрөнгийн зүй зохистой ашиглалтад чухал ач холбогдолтой билээ.

Дорнод аймагт зохион байгуулагдсан төсвийн хяналтын сонголын явцаас



Баян-Өлгий аймгийн иргэдэд төсвийн мэдээллийг хүргэх уулзалтуудын явцаас



АРДЧИЛСАН, САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

Монгол Улсын өрсөлдөх чадвар

Дэлхийн эдийн засгийн форум (ДЭЗФ)-аас эрхлэн явуулдаг Дэлхийн өрсөлдөх чадварын үнэлгээнд бид 2008 оноос оролцож Монгол Улсын бизнесийн удирдах ажилтнуудаас авсан судалгааг хүргүүлж бусад оронтой харьцуулан харах боломж бүрдүүлж байна. Дэлхийн өрсөлдөх чадварын 2018 оны тайлангаас харахад Монгол Улсын өрсөлдөх чадварт ахиц гарсангүй. Манай улс авбал зохих 100 онооноос 53 авснаар судалгаанд хамрагдсан 140 орноос 99 дүгээрт эрэмбэлэгдэв. Өмнөх онд манай улс 138 орноос 102 дугаарт эрэмбэлэгдсэн билээ.

Өрсөлдөх чадварын индекс нь тухайн улсын хүрч чадах хөгжлийн түвшнийг тодорхойлдог эдийн

засгийн бүтээмжид нөлөөлөгч хүчин зүйлүүдийн үнэлгээнд үндэслэдэг юм. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тус тайлангийн дүнг улс орнууд анхааралтай авч үзэж бодлого, үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлдэг ажээ. Сүүлийн 10 гаруй жил бид энэхүү Өрсөлдөх чадварын тайлан дахь Монгол Улсын дүнг олон нийтэд танилцуулж байгаа бөгөөд УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийн биелэлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийн тоонд өрсөлдөх чадварын үзүүлэлт орж, дэлхийд өрсөлдөх чадвар сайтай эхний 70 орны нэг болох зорилт дэвшүүлсэн юм.

Монгол Улсын өрсөлдөх чадвар (12 тулгуур үзүүлэлтээр), 2018 он



Ийнхүү Монгол Улс өрсөлдөх чадварын хувьд авбал зохих онооноос дөнгөж талаас илүү хувийг авсан нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх талаар дорвитой ахиц гаргах шаардлагатай байгааг харуулж байна. Ялангуяа институциудын чанар, дэд бүтэц болон санхүүгийн зах зээлийн хөгжил гэсэн үзүүлэлтүүдийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Өрсөлдөх чадварын индексийн дүн нь засгийн газар, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагуудын дунд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд зохих хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна. (Дэлхийн өрсөлдөх чадварын 2018 оны тайланг бүрэн эхээр нь <https://www.weforum.org/reports> хуудаснаас үзнэ үү)

ТӨСВИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ: 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН

11 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, СОНСГОЛ

- “Монгол Улсын 2019 оны төсвийн орлогын төлөвлөлт” хэлэлцүүлэг, 10-р сард
- “Монгол Улсын 2019 оны төсвийн зарлагын төлөвлөлт” хэлэлцүүлэг, 10-р сард
- ННФ-ын дэмжлэгтэйгээр төсвийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудаас Дорнод, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Өмнөговь, Төв аймгууд болон Баян-Өлгий аймгийн Улаанхүс, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумдад орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулсан төсвийн сонсгол – 9 удаа

СУДАЛГАА:

- Монгол Улсын 2019 оны төсвийн төсөл дэх уул уурхайн салбарын орлогын шинжилгээ
- Монгол Улсын 2019 оны төсвийн татварын орлогын шинжилгээ
- Монгол Улсын төсвийн санхүүжилтээр 2019 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төлөвлөлт
- Улаанбаатар хотын агаарын бохирдол ба төсөв 2019
- Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн зарлагын шинжилгээ
- Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт (инфографик)
- 2019 онд бага дүнгээр санхүүжүүлж эхлээд 2020 онд дуусгах хөрөнгө оруулалтын төслүүд (инфографик)



ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ

Татвар, хуулийн
этгээдийн улсын
бүртгэлийн газруудад
ашигт малтмалын
тусгай зөвшөөрөл
эзэмшигч хуулийн
этгээдийн эцсийн
өмчлөгчийн бүртгэлийн
сан бий болж, хувьцаа
эзэмшигчдийн мэдээлэл
нийтэд нээлттэй
боллоо.

Эрдэс баялгийн салбарт ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн хуулиудыг зохих ёсоор хэрэгжүүлэхэд шахалт бий болгох, бодлогын хэлэлцүүлэгт иргэний нийгэм, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар эрх зүйн орчинд гарсан ахиц дэвшлийг хамгаалах, цаашид улам боловсронгуй болгох зорилго дэвшүүлж ажиллалаа.


Дээрх зорилгын хүрээнд 2018 онд:

- Олборлох салбарын засаглалын эрх зүйн орчныг сайжруулах, тухайлбал ОУИТБС-ыг хуульчлах;
- Эцсийн өмчлөгч болон гэрээний ил тод байдлыг хангах;
- Засаглалд тавих шаардлагыг сулруулахаас сэргийлэх зорилгоор холбогдох төрийн байгууллагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, хариуцлага, шударга ёсыг шаардан нэхэмжлэх иргэний нийгмийн чадавхыг бэхжүүлэхэд төвлөрч ажиллав.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах үйл явц тасралтгүй өрнөв. Энэ үйл явц нь ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэх эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимтэй явуулахад мөн нөлөөллөө. Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Үнэт цаасны зах зээлийн тухай, Газрын тухай зэрэг нийт 10 гаруй хуульд өөрчлөлт, шинэчлэлт орлоо. Үүнтэй холбогдуулан дээрх хуулиудын төсөлд ил тод байдал, иргэдийн оролцоо, эцсийн өмчлөгч, гэрээний ил тод байдлыг хуульчлахад чиглэсэн санал хүргүүлж, бодлогын хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэ нь ашигт малтмал, татвар болон улсын бүртгэлийн хууль тогтоомжуудад эцсийн өмчлөгчийн бүртгэлтэй холбоотой тодорхой зохицуулалт тусгагдан хэрэгжиж эхлэхэд хувь нэмэр оруулжээ. Ингэснээр эцсийн өмчлөгчийг бүртгэхэд дагаж мөрддөг байсан өмнөх зохицуулалтын зөрчлүүд арилж, хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл ил тод болоход ахиц дэвшил гарлаа. Тухайлбал татвар, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн



ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ



газруудад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн сан бий болж, хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг нийтэд нээлттэй болголоо. Тэрчлэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар эцсийн өмчлөгчийн хууль зүйн тодорхойлолтыг шинэчлэн баталснаар хууль тогтоомжийн хоорондын зөрчлийг арилгаж, ОУИТБС-ын шаардлагад нийцсэн “зөв” мэдээллийг цуглуулан авах боломж бүрдэв.

Гэсэн хэдий ч төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах замаар эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв, баталгаатай байдлыг өнөөгийнхөөс ахисан түвшинд хүргэх, улмаар нийтэд ил тод болгох шаардлагатай байгаа юм. Мөн түүнчлэн, хөрөнгийн зах зээлд өдөр тутам өөрчлөгдөж байдаг хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн мэдээллийг дээр дурдсан улсын бүртгэлийн мэдээллийн сантай холбохын зэрэгцээ үүнтэй холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох нь тулгамдсан асуудал болоод байна.

Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын талаар өмнөх жилд хийгдсэн бодлогын судалгаанд үндэслэсэн хэлэлцүүлгээ 2018 онд үргэлжлүүлэн явууллаа. Бодлогын цуврал арга хэмжээний үр дүнд ОУИТБС-д оролцогч талуудын ойлголт, хандлага сайжирч, тайлангийн маягт шинэчлэгдсэнээр ОУИТБС-ын тайлан дахь эцсийн өмчлөгчийн мэдээлэл тоо, чанарын хувьд улам бүр сайжирч байна. Эцсийн өмчлөгчийн мэдээллээ хувь хүний түвшинд зөв тодорхойлж тайлагнасан компанийн тоо 2018 онд өмнөх оноос 138–аар нэмэгдэж 184 болж өслөө. Гэхдээ энэ нь өнөөдөр хүчин төгөлдөр байгаа тусгай зөвшөөрлийн тоотой харьцуулахад тун хангалтгүй үзүүлэлт юм. Иймд тайлан гаргах үүрэг бүхий компаниудын чадавхыг нэмэгдүүлэх, ингэхдээ бизнес эрхлэгчдийн нэгдсэн холбоодоор дамжуулан хүртээмжийг нь тэлэх зорилгоор

иргэний нийгэм, бизнес эрхлэгчдийн цуврал зөвлөлдөх уулзалт эхлүүлээд байна.

Ийнхүү ил тод байдал нэмэгдэхийн хэрээр мэдээллийн чанар, хүртээмж, бүрэн бүтэн байдалд хяналт тавих, дүн шинжилгээ хийж, зөрчил дутагдлыг илрүүлэн мэдээлэхэд иргэний нийгмийн үүрэг, хариуцлага улам нэмэгдэж байна. Өнгөрсөн хугацаанд энэ чиглэлээр ажиллах мэргэшсэн судлаач, иргэний нийгэм, сэтгүүлчид бий болж хамтын ажиллагааны эхлэл тавигдаад байгаа хэдий ч эрэн сурвалжлах ажлын арга барил, хуулийн мэдлэг, гадаад хэл дээрх мэдээллийн сангуудыг ашиглах чадавх дутагдалтай хэвээр. Иймд ОУИТБС-ын Олон улсын ажлын албатай хамтран иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан эцсийн өмчлөгчийг эрэн сурвалжлах арга зүйн цуврал сургалт зохион байгуулав. Үүний үр дүнд иргэний нийгэм, сэтгүүлчдийн хамтарсан баг байгуулагдан эрэн сурвалжлах чиглэлийн ажлууд хийгдэж байна.



- <https://www.iltodgeree.mn>-ийн танилцуулга



АРДЧИЛСАН, САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ


Эрдэс баялгийн засаглалын чиглэлд төлөвлөсөн үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэхэд холбогдох салбарын яам болон төрийн байгууллагуудтай харилцан ойлголцож, хамтын ажиллагаа өрнүүлэх нь туйлын чухал. Иймээс 2017 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-тай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан бөгөөд энэ хүрээнд Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн цахим санд (www.iltodgree.mn) гэрээнүүдийг татан байршуулах ажил 2018 онд эрчимтэй хийгдлээ. Одоогийн байдлаар нийтдээ 12 төрлийн 436 гэрээг цахим санд байршуулаад байна. Удтал маргаантай хэвээр байсан газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний ил тод байдлын асуудал ч нааштайгаар шийдэгдэж, мөн дээрх мэдээллийн санд байршлаа. Цаашид гэрээний ил тод байдлыг өргөжүүлэн газрын тосны салбар дахь эрлийн ажлын болон бичил уурхай эрхлэх гэрээ зэрэг шинэ төрлийн гэрээнүүдийг цахим сангаар дамжуулан нээлттэй болгохоор ажиллаж байна. Гэрээний ил тод байдлын тогтвортой байдлыг хангахад хуулиар баталгаажуулах нь чухал байгаа бөгөөд цаашид зохион байгуулалтын

хувьд холбогдох талууд гэрээний мэдээллээ цахим санд шууд оруулах, мэдээллийн сангийн тогтвортой, найдвартай байдлыг хангахад илүү анхаарах нь зүйтэй юм.


Татвар санхүү, эрх зүй, хөрөнгө оруулалт, хөдөлмөр, байгаль орчин зэрэг асуудлыг хамарсан, техникийн шинжтэй томоохон гэрээ хэлцэлд дүн шинжилгээ хийх чадавх бүрдүүлэх нь гэрээний ил тод байдлаас шууд хамааралтай төдийгүй тодорхой мэдлэг, туршлага, цаг хугацаа шаардах ажил юм. Иймээс өнгөрсөн хугацаанд гэрээний ил тод байдлыг хангахад илүүтэй анхаарч, харин гэрээг ойлгон шинжлэх чадавх бүрдүүлэх ажлыг орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ (ОНХАГ)-нд төвлөрүүлэн сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэхүү сургалт нь Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнтэй хамтран бүсчлэн зохион байгуулагдаж 3 аймгийн 16 сумын холбогдох талуудыг хамруулан Өмнөговь аймагт болж өнгөрлөө. Сургалтаар ОНХАГ-ний чиглэлээр ажиллах хүмүүсийн чадавх бэхжихийн зэрэгцээ уг сургалтын агуулгыг цахим гарын авлага болгох замаар хүртээмжийг нэмэгдүүлж аль болох



“Эрдэс баялгийн салбарын гэрээний ил тод байдал”
УУХҮЯ-ны удирдах ажилтнуудын зөвлөгөөн
2019 оны 12 сарын 21-ний өдөр



“Орон нутгийн гэрээний агуулга, хэрэгжилт, үр нөлөө” Өмнөговь аймагт хийгдсэн говийн бүсийн сургалт, 2018 оны 3 сарын 19-20 өдөр



ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ

олон иргэний нийгмийн зүтгэлтнүүд ашиглах боломж бүрдүүлэхийг зорьж байна. Орон нутагт уул уурхайн үзүүлэх үр өгөөж, нийгэм байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэхэд ОНХАГ чухал үүрэгтэй байдаг. Иймээс уг гэрээний эрх зүйн орчинд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөх зорилгоор бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлага тулгамдаад байгаа нь дээрх бүсийн уулзалт, сургалтуудаас харагдлаа.

Орон нутагт цөөнгүй гардаг эрдэс баялгийн салбарын үйл ажиллагаатай холбогдох зөрчлийг бууруулахад тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах гэрээний үүрэг хариуцлага чухал билээ. Иймээс бид тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах гэрээний үүргийн зөрчилд хариуцлага тооцуулах жишиг тогтоох зорилтот тэтгэлэг олгов. Үүний үр дүнд Дорнод аймгийн Захиргааны хэргийн шүүхээс Матад, Халхгол сумдын Засаг дарга нарт хуулийн дагуу газрын тосны компанитай гэрээ байгуулахыг даалгасан шийдвэр гаргаад байна. Хуулийн хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдол бүхий шүүхийн уг шийдвэрийг олон нийт, ялангуяа бусад орон нутгийн захиргааны ажилтнуудад нөлөөллийн

ажил хийхдээ сайн туршлага болгохоор төлөвлөж байна.


Эрдэс баялгийн салбарт чухал нөлөө бүхий олон улсын санаачилга болох ОУИТБС-ын удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтэд 2018 онд гэнэтийн томоохон өөрчлөлт гарлаа. Манай улс 2006 оноос хойш энэхүү санаачилгыг амжилттай хэрэгжүүлж ирсэн билээ. Олон улсын зүгээс ил тод байдлын тайлан мэдээ бэлтгэх үйл ажиллагааг төрийн байгууллагуудын чиг үүрэгт тусган хэвшүүлэх шаардлагыг Санаачилгын зүгээс тавиад байна. Энэхүү өөрчлөлт нь ОУИТБС-ын хэрэгжилтийг шинэ түвшинд гаргаж, тайлан бэлтгэхэд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулахын хамт мэдээллийн баталгаа, ач холбогдол, шуурхай байдал, төрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой бөгөөд зайлшгүй юм. Гэхдээ энэ үйл явдал Монгол Улсын хувьд ОУИТБС-ын хэрэгжилт хуульчлагдаагүй байгаа үед түүний удирдлага, зохион байгуулалтыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнээс гаргаж, салбарын яаманд шилжүүлэх Засгийн газрын шийдвэртэй давхцав. Энэ нь манай улсын хувьд ил тод



ТАН эвслийн бүх гишүүдийн хурал: Тайлагнал, төлөвлөлт, Улаанбаатар хот, 2019 оны 10 сарын 10-11 өдөр



Хариуцлагатай уул уурхайн индекс дүн танилцуулах уулзалт: Хариуцлагатай уул уурхайн сан ТББ-ын гүйцэтгэх захирал Helene Piaget, 2018 оны 7 сарын 4-ний өдөр



АРДЧИЛСАН, САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

байдлын хэрэгжилтийг сулруулж, төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн тэгш оролцоо бүхий засаглалын бүтцийг алдагдуулах эрсдэл дагуулна. Энэхүү эгзэгтэй цаг мөчид иргэний нийгмийн байгууллагууд байр сууриа шуурхай тодорхойлж, Үндэсний зөвлөлийн дэмжлэгийг авч чадсанаар ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх бие даасан хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг ҮҮХҮЯ-ны дэргэд байгуулагдаад байна.

Эрх зүйн орчинд гарсан ахиц дэвшлийг сахин хамгаалах, бодлого шийдвэр гаргахад иргэний нийгмийн оролцоог хангах, ил тод байдал, хариуцлагыг бууруулсан, хууль зөрчсөн үйл ажиллагаанд шуурхай хариу үзүүлэх бүтэц бий болгох зорилгоор иргэний нийгмийн хяналтын /watchdog/ бүлгийг ажиллуулж эхэллээ. Тодорхой удирдамжийн хүрээнд ТАН эвслийн гишүүн байгууллагуудын ээлжлэн хэрэгжүүлж буй хяналтын үндсэн дээр өнгөрсөн 2018 онд 5 уулзалт-хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт 14 хууль тогтоомжийн төсөлд санал шүүмж хүргүүлжээ.

Тэрчлэн, хяналтын бүлгийн хүрээнд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц, Алт-2 хөтөлбөр, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, төлбөрийн хэмжээг багасгах оролдлого зэрэг хууль зөрчсөн үйл ажиллагаатай холбоотой шаардлага, нэхэмжлэлүүдийг гаргаад байна. Тухайлбал, Алт-2 хөтөлбөрийн хүрээнд Төв аймгийн Заамар суманд хууль бусаар олгогдсон 21 000 га талбай бүхий ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлуулах нэхэмжлэлийн хүрээнд Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журамд хууль бусаар орсон нэмэлт өөрчлөлтийг цуцлуулж, тусгай зөвшөөрлийн талбайг 3900 га болгож бууруулав. Энэхүү тусгай зөвшөөрлийг олгох үндэслэл болсон эрх зүйн акт цуцлагдсан учраас дээрх тусгай зөвшөөрлийг цуцлуулах

нэхэмжлэлийг Захиргааны хэргийн шүүхэд дахин гаргасан нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байна. Мөн Заамар суманд Туул голын хамгаалалтын бүсэд хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа Эко Алтан Заамар ХХК-ийн үйл ажиллагаа, байгаль орчинд учруулж буй хохирлыг олон нийтэд мэдээлж, холбогдох талуудад гомдол гаргаснаар тусгай зөвшөөрлийг цуцлуулах дүгнэлтийг БОАЖЯ-аас гаргууллаа. Энэ хүрээнд Улсын мөрдөн байцаах газар, Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ерөнхийлөгчийн Тамгын газарт шаардлага хүргүүлснээр Ерөнхийлөгчийн Тамгын газар, АМГТГ, МХЕГ, АТГ, УМБГ-ын VI хэлтсээс хамтарсан шалгалт явуулж, хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авчээ.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-дахь Ардчилсан намын бүлгээс буцааж, Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, БОАЖ-нд хууль хэрэгжүүлж ажиллахыг даалгасан байна. Мөн хууль хэрэгжүүлээгүй БОАЖ-ны эс үйлдэхүйг тогтоолгож, хариуцлага тооцох нэхэмжлэлийг Захиргааны хэргийн шүүхэд гаргаад байна.

Иргэний нийгмийн чадавх бэхжүүлэх хүрээнд орон нутагт ашигт малтмал, байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд мониторинг хийх 6 тэтгэлэг олголоо. Мониторингоор байгаль орчинд нөлөөллийн үнэлгээний мэдээллийн ил тод байдал хангалтгүй, байгаль орчны үүргээ хэрэгжүүлээгүй аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцуулах хуулийн заалт огт хэрэгждэггүй гэх мэт салбарын засаглалд тулгамдаж байгаа асуудлуудыг илрүүлэн, дээрх зөрчлийг арилгахад чиглэсэн нөлөөллийн ажлыг мониторингийн төсөл хэрэгжүүлсэн төрийн бус байгууллагууд эхлүүлээ.



ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ



Төрийн бус байгууллагуудад хуулиар олгогдсон шинэ боломжийг ашиглан нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах замаар хариуцлага, шударга ёсыг шаардан нэхэмжлэх чадавх бэхжүүлэх зорилгоор “Иргэний нийгмийн төрд хяналт тавих оролцоо, нийтийн эрх ашгийн өмгөөлөл” сэдэвт цуврал сургалтыг төвийн 3 аймагт бусад хөтөлбөртэй хамтран зохион байгууллаа.

Мөн нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалахад хуульчдын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тэтгэлэг олгох, уулзалт хэлэлцүүлэг хийх зэргээр тодорхой ажлууд эхний шатандаа явж байна. Тухайлбал, дугуй ширээний цуврал уулзалтууд 2018 оноос эхэллээ. Тэрчлэн хүний эрх, тэр дундаа уул уурхайгаас үүдэлтэй нийтийн ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар 16 байгууллагад тэтгэлэг олгож, Хуульчдын зөвлөх бүлэг байгуулан ажиллаж байна. Зөвлөх бүлэг нь нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, өмгөөллийн стратеги тактикийг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой байгаа боловч зохион байгуулалт, ёс зүйн хувьд цаашид анхаарах асуудлууд гарснаас зогсонги байдалд ороод байна.

Эдгээр ажлын үр дүнд Шинэ эвлэл ТББ нь Ховд аймгийн ИТХ-аас баталсан хууль бус хоёр

журмыг цуцлуулж, Ангир нүдэн Мөндөөхэй ТББ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хууль бусаар баталсан БОАЖЯ-ны шийдвэрийг хүчингүй болгуулж, Буйр нуур, Халх Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн ТББ Дорнод аймгийн захиргааны хэргийн шүүхээс нэр бүхий зарим сумын Засаг дарга нарт хууль хэрэгжүүлж ажиллахыг даалгах шийдвэр гаргуулсан, Бугат Заамар, бургаст Туул ТББ нь Заамар суманд олгогдсон тусгай зөвшөөрлийг цуцлуулж, тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох журамд орсон өөрчлөлтийг цуцлуулсан гэх мэт зарим нааштай алхам хийгдлээ.

Гэвч нэхэмжлэлүүдийн дийлэнх нь шүүхийн шатанд гацаж, үр дүн нь удааширч байна. Энэ нь нэг талдаа нийтийн эрх ашгийн өмгөөллийн талаарх шүүхийн ойлголт хандлага муу, төрийн бус байгууллага, хуульчдын чадавх сул байгаатай холбоотой хэдий ч эрх зүйн орчны тодорхойгүй байдал, шүүгчийн хандлагаас үүдэлтэй бэрхшээл давамгайлж байна. Иймээс энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт дүн шинжилгээ хийж, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх замаар дээрх дутагдлыг арилгахад чиглэсэн нөлөөллийн ажил явуулах шаардлагатай хэвээр байна.



Иргэдийн байгаль орчны мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь: STRIPE төслийн сургалт, семинар 2019 оны 10 сарын 30-31 өдөр



“Иргэдийн байгаль орчны мэдээлэл авах эрхийг баталгаажуулах нь” төслийн хэрэгжүүлэгч байгууллагууд Хан-Уул дүүргийн Туул тосгонд ажиллаж байна. 2019 оны 10 сарын 30-31 өдөр

ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ: 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН

15 УУЛЗАЛТ, ХУРАЛ

Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын асуудлаар

- Иргэний нийгэм, хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалт – 2 удаа
- Монгол, Украин улсуудын туршлага солилцох уулзалт
- Ашиг хүртэгч эздийн асуудлаарх иргэний нийгэм, сэтгүүлчдийн нөлөөллийн багийн уулзалт -2 удаа

Гэрээний ил тод байдал, нийтийн эрх ашгийн өмгөөллийн чиглэлээр

- “Гэрээний ил тод байдал” УУХҮЯ-ны удирдах албан тушаалтнуудад мэдээлэл өгөх уулзалт
- Нийтийн эрх ашгийн өмгөөлөгчдийн дугуй ширээний уулзалт -2 удаа

ТАН эвслийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр

- Хариуцлагатай уул уурхайн индексийн дүнг танилцуулах уулзалт
- Нөлөөллийн буюу иргэний нийгмийн хяналтын бүлгийн уулзалт -5 удаа
- Бүх гишүүдийн хурал

6 СУРГАЛТ

- Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын асуудлаар иргэний нийгмийнхэн болон сэтгүүлчдэд зориулсан “Эрэн сурвалжлах арга зүйн сургалт – 2 удаа
- “Орон нутгийн гэрээний агуулга, үйл явц” сэдвээр чадавх бэхжүүлэх говийн бүсийн сургалт
- ТАН эвслийн чадавх бэхжүүлэх “Нийгмийн сүлжээг үр дүнтэй ашиглах нь” сургалт
- Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулахад чиглэсэн “ХЭХ-ын зохион байгуулалт” сургалт – 2 удаа

- “Газрын тосны бүртгэл, тооцооны журам”, “Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”, “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм” Хуулийн шүүмж 17-19
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулалт
- Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага



ЭРХ ЗҮЙН



ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ



ХҮНИЙ ЭРХ

Монгол Улс дахь хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах, олон нийтийн хүний эрхийн боловсрол, мэдлэгийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагатай үр дүнтэй хамтран ажиллах нь бидний гол зорилт билээ.

ННФ төр, төрийн бус байгууллага (ТББ), олон улсын байгууллагуудтай хүний эрхийн үндэсний механизмыг бэхжүүлэх, хүний эрхийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр сүүлийн 10 гаруй жил тасралтгүй ажиллаж ирлээ. Үүний дүнд хүний эрхийн асуудлаар ажилладаг ТББ-уудын сүлжээ бэхжиж, үйл ажиллагаа нь тогтмолжлоо. Түүнчлэн хүний эрхийн мэдлэг, мэдээлэл түгээх суваг, үйл ажиллагааны шинэ форматууд бий болж, түүнд оролцох төрийн болон төрийн бус байгууллагын хүрээ тэлж, насны бүлгийн төлөөлөл ч нэмэгдэн тодорхой хэмжээгээр эрэлттэй болж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Өнгөрсөн онд Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форум (цаашид ХЭФ гэх) UPR-Info олон улсын ТББ-тай хамтран НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг”-ээс Монгол Улс хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан 150 зөвлөмжийн хэрэгжилтийг нийслэл, 21 аймгийн иргэд, иргэний нийгмийн оролцоотой хэлэлцэж, төрийн байгууллагуудтай зөвлөлдөх замаар дүгнэлээ.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс авсан энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийн дунд хугацааны тайлан бэлтгэх хүрээнд ХЭФ иргэний улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм соёлын эрх, хүүхэд, эмэгтэйчүүд, бусад бүлгийн эрх гэсэн 5 бүлэгт хуваагдан ажиллалаа. Уг тайлан бэлтгэх явцад цуврал хэлэлцүүлгийг нийслэл төдийгүй орон нутагт зохион байгуулж, хүний эрхийн хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэхэд иргэдийн оролцоог тэлсэн нь чухал алхам болов. Ийм өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэхэд UPR-Info олон улсын ТББ-ын санхүүгийн дэмжлэг, ХЭҮК-ын орон нутгийн ажилтнуудын туслалцаа тун чухал байлаа. Цуврал хэлэлцүүлэгт нийслэл, орон нутгийн нийт 700 орчим хүн оролцож, тайлан бэлтгэх үйл явц 10 орчим сар үргэлжиллээ. Энэ бүхний дүнд Монгол Улс хоёр дахь хэлэлцүүлгээс хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан 150 зөвлөмжийн 15 хувийг бүрэн хэрэгжүүлсэн, 66 хувь хэрэгжих шатандаа, 19 хувь нь огт хэрэгжээгүй гэж дүгнэлээ. ХЭФ тус тайланг НҮБ-д хүргүүлээд байна.

ХЭФ нь хүний эрхийн чиглэлээр хяналт тавьж, шаардлагатай үед хамтарсан нөлөөлөл, хамгааллын үйл ажиллагааг явуулдаг болсноороо хүний эрхийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн бие



даасан, хөндлөнгийн институт болон бэхжиж байна. Үйл ажиллагаагаа тогтмолжуулах, хүний эрхийн чиглэлээр хүлээсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд чадавхтай, идэвхтэй гишүүн байгууллагын гүйцэтгэх хувь нэмэр өндөр тул энэ зорилтоо хэрэгжүүлэхэд нь зориулж ХЭФ-ын гишүүн байгууллагуудад ННФ-аас тэтгэлэг олголоо. Уг тэтгэлэг нь гишүүн байгууллагууд хүний эрхийн тодорхой сэдвээр мэргэших, хэрэгжилтэд байнгын хяналт тавихад чиглэсэн мэдээлэл цуглуулах, эх сурвалжаа тодорхой болгох, зөрчлийг баримтжуулахад шаардлагатай үйл ажиллагаанд зарцуулагдах юм.

Түүнчлэн, хүний эрхийн үндэсний механизмыг бэхжүүлэхэд эрх зүйн орчны нөлөө чухал тул ННФ энэ чиглэлээр хэлэлцэгдэж буй хуулийн төсөлд бусад оролцогчидтой хамтран санал, шүүмж өгөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход шаардлагатай судалгаа шинжилгээг дэмжиж ажиллалаа. Энэ хүрээнд Хүний эрхийн хамгаалагчийн тухай, Хүний эрхийн үндэсний комиссын тухай, Ашгийн төлөө бус байгууллагын тухай хуулийн төслүүд дээр ажиллаж байна. Тухайлбал, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг Парисын зарчимд бүрэн нийцүүлэх, ялангуяа, ХЭҮК-ын хараат бус байдлыг хангахад чиглэсэн гишүүнд тавих шаардлага, томилгоотой холбоотой тусгай саналууд, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх механизмын хараат бус, үр нөлөөтэй ажиллагаа, энэ явцад иргэний нийгмийн оролцоог хангах зэрэг асуудлаар тодорхой зохицуулалт тусгуулахад анхааран ажиллаж байна.

Бид хүний эрхийн боловсрол, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхдээ олон нийтийн хэлэлцүүлэг, лекц, өглөөний уулзалт, кино хэлэлцүүлэг зэрэг аль

болох өргөн олныг хамарсан шинэлэг арга хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг зорьдог билээ. Эдгээр үйл ажиллагааны агуулга болон хамрах хүрээ нь жилээс жилд өргөжин тэлж байна. Хэлэлцүүлгийг аль болох нийгэмд өрнөж буй хүний эрхийн “халуун” сэдвээр өрнүүлэхийг эрмэлздэг бөгөөд хүний эрхийн асуудлыг олон талаас авч хэлэлцэхийг зорихын зэрэгцээ, асуудалд хамаарах бүх талыг татан оролцуулахыг хичээдэг. Тухайлбал өнгөрсөн онд технологийн дэвшил, урлагийг хүний эрхийн салбарт хэрхэн үр нөлөөтэй ашиглах боломж, хүний эрхийн нөхцөл байдлыг дээрдүүлэхэд сэтгүүлч, иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг, үр нөлөөг хэрхэн нэмэгдүүлэх зэрэг асуудлыг мэргэжилтнүүдийн оролцоотой хэлэлцсэний зэрэгцээ, ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, залуучуудын эрхийн асуудалд талуудын анхаарлыг хандуулахыг зорилоо.

Мөн шүүхийн гүйцэтгэх үүрэг, төрийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийг баталгаажуулах замаар хүний эрхийн салбарт ахиц гаргах тухай ч ярилцсан болно. Үүний зэрэгцээ, чөлөөтэй зорчих эрхийг баталгаажуулах, жендерийн тэгш байдлыг хангах, шударга шүүхээр шүүлгэх баталгаа, бэлгийн цөөнх, байгаль орчны эрхийн асуудал, цаазаар авах ялыг халах асуудлын хүрээнд кино хэлэлцүүлгийг нийслэл, орон нутагт өрнүүлээ.

Товчлон дүгнэвэл, бид 2018 онд төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлж, хүлээсэн үр дүндээ хүрсний зэрэгцээ цаг үеийн байдлаас урган гарсан хүний эрхийн асуудлаар “яаралтай” акц хийх, төрийн холбогдох байгууллагуудад санал, шаардлага хүргэж ажиллалаа.

ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

ХҮНИЙ ЭРХИЙН СЭДВЭЭРХ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

КИНО ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

■ ХОВД, ӨМНӨГОВЬ
■ АЙМГИЙН КИНО
■ ТЕАТРУУДАД:




iCinema КИНО ТЕАТРТ:



“PINK” буюу “Хүлцэл”,
Найруулагч: Анируддха Рой
Чоудхури, Гол дүрүүдэд:
Амитабх Баччан, Таапсии
Панну, Кирти Кулхари,
Андреа Тарианг,




“Түцний охид”, Найруулагч:
Д.Галбаяр, Гол дүрүүдэд:
С.Сарантуяа /МУАЖ/, Т.Хулан
/МУСТА/, Т.Бадамжав,
Б.Жаргалсайхан /МУГЖ/,



“True Crime”, Найруулагч:
Клинт Иствуд, Гол дүрүүдэд:
Клинт Иствуд, Исайя
Вашингтон, Лиза Гэй Хэмилтон



“48 цаг кино наадмын шилдэг бүтээлүүд”





6 ОЛОН НИЙТИЙН ЛЕКЦ

- “Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм дахь иргэний нийгмийн оролцоо”, “Бүх Нийт Боловсролын Төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн дэд зохицуулагч Б.Болорсайхан
- “Технологи-Хөгжил-Хүний эрх” Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч Ж. Хунан
- “Хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх” Хүйсийн тэгш эрхийн төвийн тэргүүн Г.Ганбаясгах
- “Урлагаар дамжуулж хүний эрхийн боловсрол олгох нь” Монгол Улсын Төрийн соёрхолт, Ардын жүжигчин, УДЭТ-ын Уран сайхны удирдагч Н.Сувд
- “Эрх зүйт төр ба захиргааны шүүх” Улсын Дээд Шүүхийн Шүүгч, Хууль зүйн ухааны доктор Г.Банзрагч
- “Эдийн засгийн эрх чөлөө” Эдийн засагч, нийтлэгч Д.Жаргалсайхан

10 ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ

- “Иргэний нийгэм ба Ардчиллын үнэт зүйл”, “Хувийн үнэт зүйл”: Глоб интернэшнл төв ТББ-ын Тэргүүн Х.Наранжаргал, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн дэд зохицуулагч Б.Болорсайхан
- “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль ба Хүний эрх”: Гүнж төвийн Тэргүүн Ч.Ундрах
- “Эрдэс баялгийн салбарын ашиг хүртэгсдийг ил болгох нь”: ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг
- “Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл”: ХЭҮК-ын ахлах референт Х.Мөнхзул, Эмнести Интернэшнл байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа
- “Төрийн ил тод хариуцлагатай байдал”: ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан
- “Хүүхэд бичиж байна: Хүүхдийн эрхийн зөрчлүүд”: Гүүд Нэйборс олон улсын төрийн бус байгууллагын зөвлөх Х.Баавгай
- “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээ”: Монголын тэргэнцэртэй иргэдийн Үндэсний холбооны тэргүүн Б.Чулуундолгор
- “Хүний эрхийн хамгаалагч-Сэтгүүлч”: ХҮЭК-ын дэргэдэх “Хүний эрхийн төлөө сэтгүүлчид” клубын гишүүд
- “Хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилтийн зарим асуудал”: ХЭҮК-ын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга Т.Ихтамир
- “Ахмад настны эрх ба төрийн үйлчилгээ”: Монголын Ахмадын холбооны Ерөнхийлөгч Ц.Сүхбаатар







ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХИЙН ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүний эрхийн төлөв байдлын дунд хугацааны тайлангийн хүрээнд ХЭҮК ХЗДХЯ, ГХЯ-тай хамтран нийт 19 аймагт, хэлэлцүүлэг болж, 5 ажлын хэсэг тогтмол ажиллав. Мөн бүсийн уулзалт 4 удаа, нийслэлд 21 аймгийн төлөөллийг оролцуулсан уулзалт зөвлөгөөн; төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, UPR-Info олон улсын төрийн бус байгууллагатай хамтарсан үндэсний зөвлөлдөх уулзалт зохион байгуулав.

Иргэний нийгмийн өдрийг тохиолдуулан УДЭТ-т “Мэдээллийн зах” арга хэмжээ болж, дунд хугацааны тайланг НҮБ-ын ХЭДКГ-т хүргүүлэн, www.upr-info.org; www.upr-mongolia.mn цахим хуудсуудад байршуулав.



Иргэний нийгмийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Мэдээллийн зах” арга хэмжээний үеэр, 1 сарын 30, 2018





ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

Эрх зүйн шинэчлэлийн үйл явцыг бие даасан судалгаа, мониторингийн үр дүнгээр хангахын зэрэгцээ, хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх шатанд мэдлэг, мэдээлэлтэй иргэний нийгэм, залуучуудын бодитой оролцоог бий болгохыг зорьж ажиллав.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл эхлээд 5 орчим жил үргэлжилж байна. Харин шинэчлэлийн хүрээнд баталсан хууль тогтоомжууд нэг жил гаруйн хугацаанд хэрэгжиж байгаа юм. ННФ 2018 онд шинээр гарсан эдгээр хуулийн хэрэгжилтэд холбогдох бүх талын оролцоотой үнэлгээ хийж шинэчлэлийг гүнзгийрүүлэх, эрх зүйн орчныг төгөлдөржүүлэхэд шаардлагатай мэдлэг, мэдээллээр гол оролцогчдыг хангахыг зорьсон. Энэ явцад (i) иргэний нийгмийн бодит оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч, (ii) хуулийн болон хууль сахиулах байгууллагад техникийн туслалцаа үзүүлж, (iii) эрх зүйн шинэчлэлийн талаар мэдлэг, мэдээлэл түгээх чиглэлээр уулзалт хэлэлцүүлэг, хурал, жүжиг, залуучуудад зориулсан зуны сургалт зэрэг 10 гаруй үйл ажиллагааг зохион байгууллаа.

Эрх зүйн шинэ орчныг иргэний нийгэмд таниулах, энэхүү шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд иргэний нийгмийн дуу хоолойг сонсгох зорилгоор 2014 оноос эхлүүлсэн “Хуулийн хэлэлцүүлэг” нь ихэвчлэн хуулийн төслийн хүрээнд өрнөж, оролцогчдын хууль, эрх зүйн мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэхэд түлхэц болж байсан. Үүний үр дүнд иргэний нийгмийн байгууллагууд хэрэгжиж байгаа хуулиудад хамтарсан үнэлгээ хийх арга барилд суралцаж байгаа бөгөөд 2018 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай зэрэг таван хуулийн хэрэгжилтэд тус тус үнэлгээ хийж, хэлэлцүүлэг өрнүүллээ. Мөн түүнчлэн хуулийн төсөлд санал, зөвлөмж өгөх ажлаа үргэлжлүүлж Татварын ерөнхий хуулийн төсөлд иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс гаргасан санал, шүүмжийг нэгтгэн холбогдох газруудад хүргэв.

Эрх зүйн шинэчлэлд иргэний нийгмийн оролцоог дэмжих өөр нэг хэлбэр нь тодорхой чадавх бүрдсэн төрийн бус байгууллагуудад тэтгэлэг олгох замаар шинэчлэлийн хүрээний тодорхой асуудлаар хийх мониторинг юм. 2014 оноос хууль сахиулах салбарт мониторинг хийх иргэний нийгмийг чадавхжуулах зорилт дэвшүүлж нийслэл, 21 аймгийн 300 гаруй төрийн бус байгууллагыг хоёр шатны сургалтад хамруулсан билээ. Танхимд сурсан зүйлээ практикт турших боломж олгох зорилгоор



ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

сургалтад хамрагдсан байгууллагуудад нэгдсэн удирдамжаар мониторинг хийх тэтгэлэг олгов. Нэгдсэн удирдамжаар нийслэл, 21 аймагт аймаг, нийслэлийн ИТХ-ын дэргэдэх Иргэний зөвлөл, Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаанд хийсэн мониторингийн дүнг нэгтгэн 2018 онд хоёр инфографик гаргаж, олон нийтэд хүргэлээ. Мөн энэ онд цагдаагийн албаны үйл ажиллагааны ил тод байдал, ажлаа тайлагнах явцад мониторинг хийхээр 26 төрийн бус байгууллага тэтгэлэг аваад ажиллаж байна. Эдгээр байгууллага нь нийслэл болон 17 аймагт ажиллаж буй.


Тодорхой асуудлаар тухайлбал, цагдаагийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийж чадавхажсан байгууллагуудыг үндэсний

хэмжээний судалгааны ажилд татан оролцуулах боломж бүрдлээ. Үүний нэг жишээ нь “Цагдаагийн байгууллага: Хэрэглэгчийн үнэлгээ” судалгаа (энэ тайлангийн “Хэвлэгдсэн бүтээгдэхүүн” хэсгийг харна уу) байв. Энэхүү судалгаа нь цагдаагийн шинэчлэл хэрэгжсэнээс хойш анх удаа үндэсний хэмжээнд олон улсын арга зүйг ашиглан хийгдсэнээрээ онцлогтойгоос гадна манай сургалтад хамрагдсан нийслэл, 21 аймгийн төрийн бус байгууллагууд асуумжийн судалгааг авч, тайланг энэ чиглэлийн мэргэжлийн судлаачид боловсруулсан нь чухал ач холбогдолтой болсон юм.

Хаалттай уламжлал бүхий салбарыг олон нийтэд түшиглэсэн хууль сахиулах салбар болгох шинэчлэлд ийнхүү иргэний нийгмийн үүрэг

Монгол Улс дах гэмт хэргийн цагаан ном 2016 практик хэрэглээ хэлэлцүүлэг, Улсын Ерөнхий Прокурорын орлогч Г.Эрдэнэбат, 4 сарын 18, 2018





ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

оролцоо өсөн нэмэгдэж байгаа нь туйлын чухал билээ. Хууль сахиулах салбарт хөндлөнгийн ажиглалт, мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагуудын сонирхол нэмэгдэхийн хэрээр тэдний гүйцэтгэсэн ажлын чанар бас сайжирч байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Олон жилийн хүчин чармайлтын дүнд одоогоор нийслэл, 21 аймгийн 80 орчим төрийн бус байгууллага энэ салбарт тодорхой асуудлаар мониторинг хийж, туршлага хуримтлуулаад байна.

Эрх зүйн шинэчлэлд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ хууль сахиулах байгууллагад хүний эрхийг хангаж ажиллахад нь зарим техникийн туслалцаа үзүүлж, судалгаа, шинжилгээ хийх чадавх бүрдүүлэхэд анхаарч ирлээ. Тухайлбал, өнгөрсөн онд боловсруулсан алба хаагчдад зориулсан гарын авлага, сургалтын хөтөлбөрийн дагуу орон нутгийн

салбарын нийт алба хаагчдын төлөөллийг оролцуулан сургалт зохион байгууллаа. Энэхүү сургалт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуяглан хүргэх эрэн сурвалжлах тасагтай байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хийгдсэн болно.

Монгол Улсад өрнөсөн эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн дүнд хуулиудаа баталж, хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явц судалгаа, шинжилгээнд тулгуурлахаас илүүтэй, тодорхой субъектийн хувийн амбицаас ихээхэн хамааралтай байдлаар өрнөж байгаад бид санаа зовниж, энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийхийг зорьж байна. Энэ зорилгын хүрээнд Монголын криминологичдын холбоотой 2017 оноос хамтран ажиллаж байгаа бөгөөд “Гэмт хэргийн цагаан ном – 2017”-г олон нийтийн хүртээл болоход санхүүгийн дэмжлэг үзүүллээ.




Уг ном жил бүр гардаг болсноор гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөх боломж олгохын зэрэгцээ манай улс гэмт хэргийн нөхцөл байдлаараа дэлхийд ямар түвшинд байгаагаа үнэлэхээс гадна нийслэл, аймгуудын гэмт хэргийн нөхцөл байдлыг харьцуулах боломж бүрдсэн. Бид энэхүү номыг тогтмол гаргах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс 2016, 2017, 2018 оны тоон мэдээг гаргахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн билээ. Энэ хүрээнд анхаарах өөр нэг асуудал бол судалгаа хийх чадавхыг бий болгох явдал бөгөөд өнгөрсөн онд захиалгаар гүйцэтгүүлсэн гурван судалгааны тайланг сайжруулах чиглэлээр багуудтай хамтран ажиллалаа.

Эрх зүйн шинэчлэлийн явцад зарим ухралт гарч, мөн дэвшилттэй зохицуулалтууд хэрэгжих шатандаа гажуудаж байгаа зэргээс үүдэн эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор тодорхой үйл ажиллагааг санаачлан хийх шаардлага тулгарсан. Тиймээс шинээр хэрэгжиж эхэлсэн эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд шууд оролцогч талуудыг хамарсан цуврал хэлэлцүүлэг өрнүүлж, хууль хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлыг нэг мөр тодорхойлох ажлыг Монголын Хуульчдын Холбоо (МХХ)-той хамтран хэрэгжүүллээ. Тус цуврал хэлэлцүүлэгт нийт 300 орчим хуульч, хууль сахиулагч, төрийн бус байгууллагын ажилтнууд оролцож, дөрвөн хуулийн хүрээнд 90 нийтлэг санал, 266 тусгай санал гарган Хууль Зүй Дотоод Хэргийн Яам (ХЗДХЯ)-д хүргүүллээ. Зөвхөн санал хүргүүлээд зогсох бус хэрэгжүүлэхэд хамтран ажиллах үүднээс ХЗДХЯ, МХХ-той Санамж бичиг байгуулан ажиллаж байна. Санамж бичгийн

дагуу шинэ хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, холбогдох хуулийн хүрээнд ажиллах хуульч, хууль сахиулагчдыг чадавхжуулах, мөн хуулиудын тайлбарыг гаргах юм. Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд баталсан хуулиуд хэрэгжээд жил гаруй хугацаа өнгөрч байгаа хэдий ч шинэ зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэх, ололтыг бататгах, ухралтыг засаж залруулахад цаашид ч хүчин чармайлт тавих шаардлага тулгарч байна.

Эрх зүйн шинэчлэлийн шинэлэг зохицуулалт, мэдлэг мэдээллийг олон нийтэд энгийн, ойлгомжтой арга хэлбэрээр хүргэхийг зорьж театр, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарсан ажлууд хийж байгаа нь үр өгөөжтэй байхын дээр шинэчлэлийн явцад залуучуудыг татан оролцуулахад тустай үйл ажиллагаа болж байна. Шинээр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хүний эрхийг баталгаажуулсан цагдан хорих хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой шинэлэг зохицуулалтыг олон нийтэд хүргэх зорилгоор гурван бэсрэг жүжгийг Глоб интернэшнл төв төрийн бус байгууллага, Улсын драмын эрдмийн театр (УДЭТ)-тай хамтран УДЭТ-ын тайзнаа тоглууллаа.

Эрх зүйн шинэчлэл хэрэгжих шатандаа гажуудаж, зарим талаараа ухралт гарч байгаа нь олон нийтэд хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал, зохицуулалтыг таниулах, сурталчлах ажиллагаа дутмаг, мэдлэг мэдээлэл хомс байсан хэмээн үзэж энэ чиглэлээр Бат солюшн ХХК-тай хамтран эрүүгийн хууль тогтоомжийг олон нийтэд танилцуулах хэвлэл мэдээллийн гурван сарын кампанит ажил өрнүүллээ.



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

Түүнчлэн, эрх зүйн шинэчлэлд залуучуудын үүрэг оролцоо чухал хэмээн үзэж залуучуудыг мэдээллээр хангах, тэдний утга агуулгатай оролцоог бий болгоход хувь нэмэр оруулах үүднээс 2018 оноос Залуучуудын хөтөлбөр хэрэгжүүлж эхэллээ. Эхний ээлжид Хууль сахиулах их сургууль, Шихихутуг их сургууль, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн оюутан залуустай хамтран ажиллаж байна. Нийт оролцогчдоос сонгогдсон 25 оюутныг оролцуулан Хүний эрхийн зуны сургалт зохион байгууллаа. Тус сургалтаар залуучуудыг чадавхжуулахын зэрэгцээ хүний эрхийн боловсрол мэдээллийг түгээн дэлгэрүүлэх

шинэлэг арга зүйг албан болон албан бус боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулах билээ. Дээрх хүчин чармайлтын үр дүнд манай хөтөлбөрт оролцсон залуучууд 9, 12-р саруудад зохион байгуулсан олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны үеэр Эмнести интернэшнл монгол төрийн бус байгууллагын залуучуудын бүлэгтэй хамтран “Жигүүрээ дэлгэ” аяныг санаачиллаа. Уг аяны хүрээнд шинэ эрүүгийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулсан билээ.

Бид энэ онд зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, сургалтад нийт 416 цаг буюу 52 ажлын өдрийг зарцуулж, 2700 орчим хүн биечлэн эдгээр үйл ажиллагаанд оролцжээ.

Залуучуудын хөтөлбөрийн залуучууд Эмнести Интернэшнл Монгол ТББ-ын залуучуудын бүлэгтэй хамтран зохион байгуулсан “Жигүүрээ дэлгэ” аян, 9 сарын 22, 2018





ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, ХУУЛЬ САХИЛУАХ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ: 2018 ОНД ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН

ХУУЛИЙН ШҮҮМЖҮҮД (17-25)

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай, Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын хэрэгжилтийн үнэлгээ (бүрэн эхээр нь www.forum.mn -ээс үзэх боломжтой.)

МОНИТОРИНГ - ИНФОГРАФИК (№13-19)

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал, Олон нийтийн цагдаа, Иргэний зөвлөл болон Багийн хэсгийн ахлагчийн үйл ажиллагаа, алба хаагчийн талаарх өргөдөл гомдлын шийдвэрлэлт, Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилтээр иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн Мониторингийн үр дүн (бүрэн эхээр нь www.forum.mn -ээс үзэх боломжтой.)



ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ГАРГАСАН СУДАЛГАА:



“Гэмт хэргийн цагаан ном – 2016” судалгааг хийж гүйцэтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлээ.



“Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ-2017” судалгааг хийж гүйцэтгэхэд санхүүгийн болон техникийн туслалцаа үзүүлж, хэвлэн нийтэлж гаргалаа.



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ:
2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

12 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- “Цагдаагийн алба хаагчийн ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж байгаа эсэхийг судлах судалгаа”-ны тайланг шинжлэх, “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016” практик хэрэглээ, “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017” судалгаанд санал авах уулзалт хэлэлцүүлгүүд;
- “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал”-аар мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, шүүгч, төрийн бус байгууллагын ажилтнууд, их дээд сургуулийн багш нарын дунд 7 цуврал хэлэлцүүлэг;
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль болон “Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх” хэлэлцүүлгүүдийг тус тус зохион байгууллаа.

5 СУРГАЛТ, БУСАД АРГА ХЭМЖЭЭ

- “Театр хүний эрхийн төлөө 2018” үйл ажиллагааны хүрээнд шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан бичигдсэн “Наран цамхгийн хэрэг”, “Манаач”, “Хуулийн өмнө” бэсрэг жүжгүүд УДЭТ-ын тайзнаа тоглогдлоо.
- Монголын хуульчдын форумын үеэр “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал” салбар хуралдаан зохион байгууллаа.
- “Хүний эрхийн зуны сургалт” зохион байгууллаа.
- Цагдаагийн албаны ил тод байдалд мониторинг хийхээр шалгарсан нийслэл, 17 аймгийн төрийн бус байгууллагын ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулав.



“Театр хүний эрхийн төлөө 2018” арга хэмжээний үеэр, 1 сарын 30, 2018



ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Дотоодын болон олон улсын сайн туршлагад тулгуурлан зөвшилцлийн хүрээнд Шүүх эрх мэдлийн индекс төслийг эхлүүлж, 2018 онд арга зүй боловсруулах шинжээчдийн зөвлөл байгуулагдаж төслийн цар хүрээг тогтоогоод байна.

ННФ нь сүүлийн 10 жилд шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх оролдлогынхоо хүрээнд шүүхийн шинэтгэлийн хөшүүрэг болсон бие даасан, хөндлөнгийн бодлогын судалгаа, мониторинг ажиглалтыг анхлан явуулж, шинэтгэлийн явцад харьцуулсан судалгаа хийх, бодлого боловсруулагчдад техникийн туслалцаа үзүүлэх зэргээр хамтран ажиллаж ирлээ. Түүнчлэн шүүхийн шинэтгэлийн хүрээнд баталсан бодлого, хууль зүйн баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх чиглэлээр судлаачдыг чадавхжуулах, хүрээг нь тэлэхэд анхаарч ажиллалаа.

Тэрчлэн бие даасан судлаачдаас гадна, шүүхийн үйл ажиллагаанд ажиглалт, мониторинг хийх иргэний нийгмийн байгууллагуудыг гаргаж ирэх, тэдэнд ашиглахад энгийн хялбар арга зүйг боловсруулж танилцуулах нь чухал байлаа. Иймээс 2010 оноос хойш шүүхийн ажиглалтын арга зүйг туршин нутагшуулж байна. 2018 онд энэхүү ажиглалтын арга зүйг гарын авлага болгон боловсруулж өмнө нь шүүхийн ажиглалтын чиглэлээр хамтран ажилласан орон нутгийн төрийн бус байгууллагуудад хүргүүлээд байна. Энэхүү арга зүйг ашиглан “Захиргааны шүүхэд төрийн албаны маргаан шийдвэрлэх маргааны ажиглалт”, Иргэний шүүхэд гэм хорын хохиролтой хэргийн ажиглалт хийх бие даасан төсөл хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхээр Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн болон Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөний Дархан салбар төрийн бус байгууллагуудад тэтгэлэг олголоо. Энэхүү тэтгэлгийн үр дүнд бусад төрийн бус байгууллагад авч хэрэглэж болохуйц загвар төсөл бий болгохоор ажиллаж байгаагаараа өмнөх төслүүдээс онцлогтой юм.

2017 оноос хэрэгжүүлж байгаа шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх төсөл нь судлаачдаас тодорхой төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж шүүхийн шийдвэрийн хууль ёсны дүгнэлт, үндэслэл болон шүүгчийн хууль хэрэглээний чадвар, мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс дүгнэлт хийж, шаардлагатай зөвлөмж боловсруулж гаргах зорилготой байв. 2018 онд дээр дурдсан анхны дүн шинжилгээний эмхэтгэл хэвлэгдэн гарч хуульчдын гарт хүрээд байна.



ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Судалгааны үр дүнг сонирхсон талуудын дунд хэлэлцүүлж, шүүмж өрнүүлэх нь нэн чухал бөгөөд МУИС-ийн ХЗС-тай хамтран салбар эрх зүй бүрээр гурван удаа цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсан нь энэ төрлийн судалгааны эрэлт хэрэгцээнд тодорхой хэмжээнд нийцсэн гэж үзэж буй.

Харин 2018 онд Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт анализ хийх хоёр удаагийн уралдаант шалгаруулалтын дүнд 11 тэтгэлэгт төсөл шалгарч дүн шинжилгээ нь хийгдэж байна (хүснэгтийг харна уу).

Шүүхийн шинэтгэлийн үйл явц 2016 оныг хүртэл эрчимтэй явагдаж, бүтэц тогтолцооны өөрчлөлт хийж эхэлсэн сүүлийн жилүүдэд шүүхийг шинэчлэх улс төрийн хүсэл эрмэлзэл алдагдаж, шинэтгэлийг бэхжүүлэх алхмууд хийгдэхгүй байна. Улмаар шүүхийн шинэтгэлийн хүрээнд гарсан ахиц дэвшлийг үгүйсгэх, буцаах эрсдэл бий болсон тул анхдагч үзэл баримтлалыг бэхжүүлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна. Ингэхдээ шүүхийн шинэтгэлийн үр нөлөөг бодитоор, салбарын хувьд бүхэлд нь үнэлж оношлох арга хэрэгсэл гаргаж ирж, түүний дагуу тогтмол үнэлж, үр дүнг олон нийтэд хүртээмжтэй, энгийн ойлгомжтой байдлаар мэдээлэх нь чухал гэж үзлээ. Иймээс дотоодын болон олон улсын сайн туршлагад тулгуурлан зөвшилцлийн хүрээнд Шүүх эрх мэдлийн индекс төслийг эхлүүлж, 2018 онд арга зүй боловсруулах шинжээчдийн зөвлөл байгуулагдаж төслийн цар хүрээг тогтоогоод байна. 2019 онд арга зүйг анхлан турших юм. “Дэлхийн шударга ёсны төсөл” олон улсын судалгааны байгууллагаас эрхлэн гаргадаг Хуульт ёсны индексийн судалгаа хариуцсан

ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ БАЙГУУЛЛАГУУД

Байгууллага	Сэдэв
Оюуны-Инновац ТББ	Захиргааны гэрээтэй холбоотой маргааны шүүхийн шийдвэр
Эрх зүйн соёл ТББ	Гэр бүл цуцлахад ипотекийн зээлийн барьцаанд байгаа дундын эд хөрөнгийг хуваах шүүхийн шийдвэр
Эрх зүйн хөгжлийн төлөө ТББ	Газар өмчлөх, эзэмших эрхтэй холбоотой хэрэг, маргааны хяналтын шатны шүүхийн шийдвэр
Хууль эрх зүйн хөгжлийн төлөө ТББ	Сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн талбай, газар, өмчийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэсэн Иргэний хэргийн шүүхийн шийдвэр
Норовсамбуу, Пүрэвбаатар нар	Орон сууцны талбай тооцохтой холбоотой хэрэглэгчийн эрхийг сэргээх шүүхийн шийдвэр
Н.Отгончимэг	Засгийн газар хариуцагчаар оролцсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр
Б.Уранцэцэг, Н.Баасанжав	Төрийн албан хаагчид ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулсантай холбоотой хөдөлмөрийн маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр
Б.Мөнхтогтох	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол
Б.Буянхишиг ба бусад	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хэргийн оролцогчийн эрх ба шүүх хуралдаан хойшлуулах шийдвэр (ИХШХШтХ 105.2 дах хэсэг)
Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар	Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах шүүхийн шийдвэр
Үнэн хатамж ТББ	Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх албадлагын арга хэмжээ авах шийдвэр



ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

захирал Сара Чамнес Лонг ННФ-ын урилгаар манай улсад хүрэлцэн ирж Монгол Улсын хууль ёсны үзүүлэлтүүдийг танилцууллаа.

Шүүхийн шинэчлэлийн явцад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай түншлэн хамтын ажиллагаа өрнүүлэх нь юу юунаас чухал. Бид Монголын хуульчдын холбоотой байгуулсан санамж бичгийн хүрээнд гурав дахь жилдээ Монголын Хуульчдын нэгдсэн форумыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран хамтран ажиллав. 2018 оны Форумд “Хараат бус шүүх ба Хууль дээдлэх ёс” сэдэвт салбар хуралдааныг ННФ зохион байгуулж хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа чиглүүлэгчээр ажиллалаа.

Шүүхийн шинэчлэлийн үр нөлөөг үнэлэхэд бие даасан хөндлөнгийн судалгааны ач холбогдол өндөр хэдий ч түүнийг бодлого

боловсруулагчид, олон нийтэд хүргэх нь бодлогын өөрчлөлт гарахад нэн чухал юм. Олон нийтэд хуульчдын хийсэн судалгаа, дүн шинжилгээг сайтар ухуулан таниулахад сэтгүүлчдийн оролцоо, хамтын ажиллагаа шаардлагатай гэж үзсэний дүнд сэтгүүлчид, судлаачдын дунд Өглөөний уулзалт тогтмол зохион байгуулж, өмнө хийгдсэн бодлогын судалгааны асуудлаар ярилцаж мэдээлэл өглөө (Энэ сэдвээр зохион байгуулагдсан арга хэмжээ хэсгийг харна уу.).

Өглөөний уулзалтын хүрээнд олж авсан мэдээлэлд үндэслэн сэтгүүлчид МҮОНТВ-ийн “Ярилцъя” шууд хөтөлбөрт “Шүүгчийн томилгоо” сэдвээр П.Баттулга судлаачийг яриулсан бол Mongol HD телевизийн Нүүдэл Шийдэл нэвтрүүлгээр “Захиргааны шүүх ба Засгийн газрын шийдвэр” сэдвээр хэлэлцүүлэг

Сара Чамнес Лонг, Эрх зүйт ёсны индексийн Судалгаа хариуцсан захирал, Хуульчдын Форум – 2018, 2018 оны 6 сарын 19

Хуульчдын Форум 2018, оролцогчид





ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

өрнүүллээ. Түүнчлэн Монголын мэдээ болон Улс төрийн тойм сонинууд, www.time.mn, www.24tsag.mn, www.trends.mn, www.news.gogo.mn, www.ikon.mn сайтуудад “Хахууль өгч шүүгч болсон хүнээс шударга шийдвэр хүлээх боломжгүй” ярилцлага (судлаач Б.Гүнбилэгийн), “Шүүгчээр томилохоос татгалзах үндэслэл тодорхойгүй гэдэг нь үзэмжээрээ шийдвэрлэх асуудал байсаар байна гэсэн үг”, “Засгийн газрыг захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гаргавал хууль дээдлэх ёс хоосон тунхаг болно” зэрэг нийтлэлүүд (судлаач П.Баттулга, О.Мөнхсайхан нарын) олон нийтэд түгээгдлээ.

2019 онд сэтгүүлчид хуульч судлаачдын хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх, хууль ёсыг дээдлэхэд хамтран ажиллах асуудлаар зөвлөлдөн Шүүгчийн томилгооны хараат бус

байдлыг шаардах ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Шүүхийн хараат бус байдлыг хангахад судалгаа шинжилгээ, нөлөөллийн ажлыг олон талын оролцоотой хавсран хэрэгжүүлэх нь чухал. Тиймээс 2018 онд ННФ нь шүүхийн чиглэлд хамтран ажиллах эрх зүйн судалгааны Оюуны Инновац ТББ-д байгууллагын хөгжлийн тэтгэлэг олголоо. Энэ тэтгэлгийн хүрээнд тус байгууллага нь стратегиа боловсруулж, дотоод засаглал, хүний нөөцөө бэхжүүлэх юм.

Цаашид үндэсний хэмжээний болон орон нутгийн иргэний нийгмээс шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, хууль ёсыг дэлгэрүүлэхэд өргөн хүрээнд, олон талууд хамтран ажиллах нь үр илүү дүнтэй болоод байна.

- А.Бямбажаргал, МУИС-ын Хууль зүйн сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D.)
- Д.Ганзориг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн
- Ц. Сарантуяа, МУИС-ийн ХЗС-ийн профессор, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D.)
- О.Мөнхсайхан, МУИС-ийн ХЗС-ийн дэд профессор, хууль зүйн доктор (LL.D.)



ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ: 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

9 ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ

- Судлаачид, сэтгүүлчдийн уулзалтын хамтын ажиллагааны зорилго, хэрэгцээ, шаардлага, чиглэлийг тодорхойлох, 4 сарын 27
- “Шүүгчийн хараат бус байдал ба олон нийтийн хяналт”, 5 сарын 18
Илтгэгчид: П.Цэцгээ, Л.Галбаатар, Ш.Батболд
- “Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо”
Илтгэгчид: Хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, Хууль зүйн ухааны доктор Б.Гүнбилэг, Судлаач, хуульч П.Баттулга, 6 сарын 8
- “Хууль ёсны индекс”, 6 сарын 20
Илтгэгч: Сара Лонг
- Хуульчдын Форумын салбар хэлэлцүүлгийн мөрөөр өгсөн зөвлөмжийн хэлэлцүүлэг, 6 сарын 29
- Нийтийн ашиг сонирхлыг шүүхэд нэхэмжлэх нь, 8 сарын 24
Илтгэгч: Оюуны Инноваци ТББ П.Баттулга, Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн ТББ, Б.Баярмаа
- Шүүхийн шийдвэрийн анализ: Гэм буруугүй нь тогтоогдож цагаатгагдсан хэргүүд ба түүний улмаас хоригдсон иргэдийн хохирлын нөхөн төлбөр, 9 сарын 14
Илтгэгч: Эрх зүйн соёл ТББ-ын төлөөлөл
- Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, 9 сарын 28
Илтгэгч: Хөгжлийн академи ТББ-ын төлөөлөл
- Гэр бүлийн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалсан байдал, 10 сарын 12
Илтгэгч: Эрх зүйн хөгжлийн төлөө ТББ-ын төлөөлөл





ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

5 СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- Шүүхийн ажиглалтын арга зүйн сургалт, 11 сарын 2
- Шүүхийн хараат бус байдал ба Шүүхийн захиргаа салбар хуралдаан, Хуульчдын Форум 2018 оны 6 сарын 19
- Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол хэлэлцүүлэг, Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн хүрээнд, 10 сарын 10 (МУИС-ХЗС-тай хамтарсан)
- Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол хэлэлцүүлэг – Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн хүрээнд, 11 сарын 7 (МУИС-ХЗС-тай хамтарсан)
- Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол хэлэлцүүлэг – Үндсэн хуулийн цэц, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хүрээнд 12 сарын 21, (МУИС-ХЗС-тай хамтарсан)
- Судлаач сэтгүүлчдийн хамтарсан семинар – Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлд сэтгүүлчид судлаачдын хамтын ажиллагааны чиглэл, хэлбэрийг тодорхойлох, 2018 оны 12 сарын 8

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ:
2018 ОНД ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН



ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Шүүхийн ажиглалт мониторинг хийх иргэний нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага бөгөөд шүүхийн ажиглалтын нэгдсэн арга зүйг энгийнээр товч тайлбарлаж оруулсан.



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЭМХЭТГЭЛ

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар шүүхийн практик, хууль хэрэглээг судалсан судалгааны тайлангууд бөгөөд эхний эмхэтгэл хэвлэгдэн гарч шүүгч, хуульчдын гарт хүрээд байна.



ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Засгийн газрын
“Бүх нийтийн эрх
зүйн боловсролыг
дээшлүүлэх үндэсний
хөтөлбөр”-ийг
хэрэгжүүлэх
Үндэсний зөвлөлийн
бүрэлдэхүүнд ННФ-
ын төлөөлөл ажиллаж
байна.

Нээлттэй Нийгэм Форум 2016 онд Хууль зүй дотоод хэргийн яамтай байгуулсан Санамж бичгийн хүрээнд “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг дэмжин ажиллахаар болж өнгөрсөн хоёр жилийн хугацаанд бид иргэдэд зориулсан хөтөч боловсруулахаас эхлээд бодлогын нөлөөллийн ажлууд, холбогдох төрийн албан хаагч, ажлын хэсгийн гишүүдийг гадаад орны туршлага судлуулах, хууль зүйн салбарт ажилладаг иргэний нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах зэргээр үр дүнтэй хамтын үйл ажиллагаа явуулж ирлээ. Тэрчлэн, хууль зүйн үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ хууль зүйн туслалцааны төвийн ажилтнуудыг сургаж чадавхжуулахад үзүүлж буй дэмжлэг тодорхой хэмжээнд үр дүнгээ өгч байгааг тэмдэглүүштэй.

Бид 2018 онд дээр дурдсан Санамж бичгийн хүрээнд төлөвлөсөн зарим ажлаа баталгаажуулсны зэрэгцээ иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх, хууль зүйн туслалцааны тогтолцоог бэхжүүлэхэд иргэний нийгмийн болон мэргэжлийн байгууллагуудын оролцоо бий болгохыг зорьж, бусад орны сайн туршлагыг авч нэвтрүүлэхэд анхаарлаа хандууллаа.

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх

2018 оны 2 сарын 14-ний өдөр Монгол Улсын Засгийн газар “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” баталлаа. Тус хөтөлбөр нь Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдлэг, мэдээллийг энгийн ойлгомжтой байдлаар бэлтгэн боловсруулж, цахим болон хэвлэмэл хувилбараар нээлттэй, хүртээмжтэй болгох замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилго дэвшүүлсэн бөгөөд 5 жилийн хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжих юм.

Нээлттэй Нийгэм Форумын төлөөлөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Хөгжлийн олон хөтөлбөр батлагддаг ч төсөв, санхүүгийн байдлаас шалтгаалан хэрэгжилт нь хангалтгүй байх тохиолдол бишгүй гардаг. Тиймээс хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд



ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

олон талын санхүүгийн эх үүсвэр бий болгох, хандивлагчдын анхаарал, сонирхлыг татах зорилгоор Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран хандивлагчдын уулзалт зохион байгуулж хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, хэрэгжүүлэх төлөвлөгөөг танилцууллаа. Уулзалтын үр дүнд хэд хэдэн олон улсын байгууллагын зүгээс эрх зүйн хөтөч бэлтгэх, албан бус сургалт болон гарын авлага, хэвлэн нийтлэлийг дэмжих зэрэг хамтын ажиллагааны тодорхой санал ирүүлсний дагуу хэрэгжилт нь эхлээд явж байна.

Монгол Улсад иргэний эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд Засгийн газрын зүгээс анхаарал тавьж, манлайлан ажиллаж байгаа нь олон улсын хэмжээнд сайшаагдахуйц алхам юм.

Тиймээс энэхүү хүлээсэн үүрэг хариуцлагыг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө бататгахад чиглэсэн хамтарсан төслийн хүрээнд олон улсын нөлөөллийн ажил зохион байгууллаа. Тухайлбал, Нээлттэй Засгийн Түншлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас илгээх Үйл ажиллагааны гуравдугаар төлөвлөгөөнд бүх нийтийн эрх зүйн боловсролыг үүрэг амлалт болгон оруулах болон Тогтвортой хөгжлийн 16-р зорилтын хэрэгжилтийн талаар үндэсний сайн дурын тайланд тусгах зэрэг үйл ажиллагааг олон улсын түвшинд хэрэгжүүлэхээр боллоо. Мөн холбогдох албаны хүмүүс, иргэний нийгмийн төлөөллийг олон улсын хурал, чуулганд оролцоход нь дэмжлэг үзүүлээ.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”
Хандивлагч байгууллагуудын уулзалтын үеэр, 2018 оны 6 сарын 8





ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

Түүнчлэн, ННФ нь Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны үүрэг хүлээн ажиллаж байгаа Хууль зүйн үндэсний хүрээлэнд эрх зүйн цахим хөтчийг боловсронгуй болгох, эрх зүйн хөтчийн хөтөлбөрийг эхлүүлэхэд нь техникийн туслалцаа үзүүллээ. Эрх зүйн цахим хөтөч албан ёсоор нээлтээ хийж, эрх зүйн хөтөч-иргэд орон нутгийнхаа иргэдэд эрх зүйн мэдээлэл өгч эхэлснээр албан ёсоор анхан шатны хууль зүйн туслалцаа, үйлчилгээний үндэсний тогтолцоо бий боллоо гэж үзэх юм.

Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх иргэний нийгмийн үйл ажиллагааг дэмжих

Хууль зүйн үйлчилгээний албан ёсны тогтолцоо ажиллаж эхэлсэн ч орон нутгийн иргэдийн онцлог хэрэгцээ шаардлага, нийгмийн тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдал, нийтлэг төрийн үйлчилгээнээс алслагдсан байдал зэрэг нь эрх зүйн мэдээлэл, үйлчилгээг бүрэн авахад тэдэнд саад тотгор болж байдаг. Олон улсын туршлагаас харахад алслагдсан,

эмзэг бүлгийн иргэдтэй ажилладаг, тэдний төлөөлөл болсон, итгэлийг нь даасан иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулж тэдэнд нэн хэрэгцээт эрх зүйн мэдээлэл, үйлчилгээг хүргэх арга үр дүнтэй болох нь харагддаг. Бидний зүгээс олон улсын хэмжээнд иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх зорилготой ажилладаг Намати байгууллагатай хамтран Монголын иргэний нийгмийн төлөөлөлд зориулан анхны танилцуулах сургалт-семинар зохион байгууллаа. Уг сургалтад эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалж ажилладаг 15 иргэний нийгмийн байгууллага оролцлоо.

Энэхүү сургалтад оролцогчдод эрх зүйн хөтчийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх туршилтын төсөлд хамрагдах урилга хүргүүлснээс Түгээмэл хөгжил төв, ЛГБТ төв, Гүнж төв, Хөөрхөн зүрхнүүд, Хил хязгааргүй алхам зэрэг 5 байгууллагад 1 жилийн хугацаатай тэтгэлэг олгоод ажиллаж байна. Эдгээр байгууллага нь үйл ажиллагааны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах, охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, гэр

Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр бүсийн уулзалтын үеэр, 2018 оны 8 сарын 28





ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

бүлийн хүчирхийлэл, бэлгийн чиг хандлагын улмаас ялгаварлан гадуурхагдаж байгаа хүмүүсийн эрх болон орон нутгийн иргэдийн амьдралд тулгамддаг эрүүл мэндийн асуудал, аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах чиглэлээр олон жил ажиллаж буй. ННФ-аас цаашид иргэний нийгэмд суурилсан эрх зүйн мэргэшсэн хөтөч нарыг ажиллуулах, улмаар тэдний үйл ажиллагааг хууль зүйн анхан шатны тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгох чиглэлд дэмжлэг үзүүлж ажиллахаар төлөвлөж байна.

Хууль зүйн туслалцааны үндэсний тогтолцоог бэхжүүлэх

Хууль зүйн мэргэжлийн туслалцааны хүртээмжийг дээшлүүлэх нь иргэд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хуулийн механизм ашиглан тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд нэн чухал дэмжлэг юм. Хууль зүйн туслалцааны төв нь Төлбөрийн чадваргүй сэжигтэн яллагдагчид өмгөөллийн туслалцаа үзүүлдэг үндэсний тогтолцоо болсноос хойш 4 жил өнгөрч байна.

Хууль эрх зүйн орчин нь бүрдэж, хариуцсан бүтэцтэй болсон нь тодорхой ахиц дэвшил хэдий ч төсөв санхүү, хүний нөөцийн хувьд бэхжих боломж хомс байгааг дурдах нь зүйтэй. Иймд тус байгууллагад үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад нь дэмжлэг болох үүднээс ННФ-аас үйл ажиллагааны тэтгэлэг олголоо. Үг тэтгэлэг нь тухайн байгууллага хуулийн шинэчлэлд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах болон үйл ажиллагааны статистик тоон мэдээлэл гаргах, хэргийн хөдөлгөөнийг удирдах цахим сүлжээтэй болоход нь зориулагдаж олгогдсон болно. Хууль зүйн туслалцааны төв нь энэхүү сүлжээний ашиглалтыг нэмэгдүүлэх үүднээс 2018 онд төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмжийн бүрэн шинэчлэл хийж чадсан нь сайшаалтай. Мөн ННФ-ын дэмжлэгтэйгээр улсын өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслахуудад компьютерын хэрэглээ, сүлжээний ашиглалтын талаар 3 өдрийн сургалт зохион байгуулснаар хууль зүйн туслалцааны тогтолцоог хөгжүүлэхэд нэгэн том алхам хийгдлээ.

МХХ-ны төлөөлөгчид Азийн про боно хуульчдын 8-р чуулгын үеэр, Хонг Конг, 2018 оны 10 сарын 25-27



Хууль зүйн туслалцааны төв, Монголын Хуульчдын Холбооны төлөөлөл Эрүүгийн эрх зүйн тогтолцоон дахь хууль зүйн үйлчилгээний хүртээмж олон улсын 3 дахь бага хурлын үеэр, Тбилиси хот, Гүрж Улс, 11 сарын 13-15, 2018





ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ

Хууль зүйн туслалцааны тогтолцоог боловсронгуй болгоход олон улсын сайн туршлага судалж суралцахад дэмжлэг болох үүднээс ХЗДХЯ-ны Эрх зүйн бодлогын газрын ажилтан Молдав Улсад болсон олон улсын хуралд оролцох, Хууль зүйн туслалцааны төвийн захирал Гүржийн Парламент, Хууль зүйн туслалцааны алба, Олон улсын эрх зүйн сан, Нээлттэй нийгэм сангуудын Эрх зүйн санаачилга, НҮБХХ, Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын албанаас хамтран зохион байгуулсан хууль зүйн туслалцааны талаар олон улсын хуралд оролцоход дэмжлэг үзүүлээ. Шинэ тутам байгууллагын хувьд дотоод, гадаадад хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал юм. Тэрчлэн, хуульчийн мэргэжлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд Монголын хуульчдын холбоотой хамтран хуульчдын про боно үйл ажиллагааг хөхиүлэн дэмжихэд хамтран ажиллалаа. Энэхүү хамтын

ажиллагааны үр дүнд хуульчдын онлайн зөвлөгөөний цахим хуудас ажиллаж эхэлсэн бөгөөд одоогоор 26 өмгөөлөгч иргэдээс ирүүлсэн захиргааны болон иргэний эрх зүйн төрөл бүрийн асуултад хариулт өгч эхлээд байна.

МХХ-ны төлөөлөгчид 2018 онд Хонконгод зохион байгуулагдсан Азийн про боно хуульчдын 8-р чуулга уулзалтад хоёр дахь жилдээ амжилттай оролцлоо. Тус олон улсын чуулгад оролцсон хуульчид үндэсний про боно хуульчдын форумыг манлайлан зохион байгуулдаг уламжлал тогтож эхэллээ. Цаашид про боно хуульчид, улсын өмгөөлөгчид, иргэний нийгмийн байгууллагууныхыг холбон хамтран ажиллахад нь дэмжлэг болох үүднээс Монголын хуульчдын холбоотой санамж бичгийн хүрээнд тэтгэлэг олгон хамтран ажиллаж байна.

ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ: 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

5 УУЛЗАЛТ, СУРГАЛТ, СЕМИНАР

- Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь семинар, 5 сарын 29-30
- Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр бүсийн уулзалт, 8 сарын 28-31
- Хууль зүйн туслалцааны төвийн Улсын өмгөөлөгчдөд зориулсан сургалт, 10 сарын 29-31
- “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” Хандивлагч байгууллагуудын уулзалт, 6 сарын 8,
- Про-Боно хэлэлцүүлэг, 12 сарын 11, 2018

БОЛОВСРОЛ,



НИЙГМИЙН БОДЛОГО



ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

2016-2018 онд
хөгжлийн бэрхшээлтэй
хүүхдийг боловсролд
тэгш хамруулах эрх
зүйн орчин бүрдэж,
оролцогч талуудын үүрэг
хариуцлага үндсэндээ
тодорхой боллоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зохих дэмжлэгтэйгээр орон нутгийн ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургаж, суурь боловсрол эзэмшүүлэх зорилт бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 онд батлагдаж, 2017-2018 онд хуулийн хэрэгжилтийг хангах хэд хэдэн тогтоол, шийдвэр гарсан билээ. 2017 онд УИХ 46 тоот тогтоолоороо шат шатны Засаг дарга нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах чиглэлд арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгон 2018 онд боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаал гарган ерөнхий боловсролын сургуульд суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, шаардлагатай хүүхдэд Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал батлагдаад байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргаа, аймаг/ дүүргийн Боловсролын газар/ хэлтэс, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбар комисс, сургуулийн захирал, багш, эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагааг дээрх баримт бичгүүдэд тодорхой заажээ. Ийнхүү 2016-2018 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах эрх зүйн орчин хурдацтай бүрдэж, оролцогч талуудын үүрэг хариуцлага тодорхой болов.

Гэвч эрчимтэй өрнөж буй эрх зүйн орчны шинэчлэлийн хурдыг хэрэгжилтийн үйл явц гүйцэхгүй байна. Хууль гарснаас хойших 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилд орон нутгийн сургуульд элсэн суралцсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэмэгдээгүй; элсэхээр ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тусгай сургууль, Насан туршийн боловсролын төвүүд рүү явуулдаг практик хэвээр байгааг иргэний нийгмийн мониторингууд харуулав. ННФ нь 2018 онд хуулийн хэрэгжилтийг шаардах, дэмжих иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах, орон нутагт иргэний нийгмийн нөлөөллийг идэвхжүүлэхэд төвлөрөхийн зэрэгцээ багш нарт арга зүй эзэмшүүлэх замаар сургуулийн түвшинд тэгш хамруулах итгэл үнэмшил, чадавх бий болгох стратегийн хүрээнд багш бэлтгэх их сургуультай түншлэн ажиллаж эхэллээ.



ННФ-ын хөгжлийн тэтгэлэгт хамрагдан, 2016 оноос хамтран ажиллаж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо (ХБХЭЭХ), Түгээмэл хөгжил төв ТББ нь тэгш хамруулах боловсролын бодлогын асуудлаар эксперт болж төлөвшиж байна. 2018 онд ХБХЭЭХ нь манай хөтөлбөрөөс зохион байгуулсан чадавх хөгжүүлэх сургалтууд, ганцаарчилсан зөвлөгөө, төслийн жижиг тэтгэлэг зэрэг дэмжлэгийн механизмуудыг идэвхтэй ашиглан, боловсролын болон эрх зүйн зөвлөн туслах хөтөлбөр, мөн бодлогын нөлөөлөл ба олон нийтийн мэдээллийн багуудаа бэхжүүлж чаджээ. Холбооны Зөвлөх эцэг эхийн хөтөлбөр бэхжиж, шинээр болон давтан сургах сургалт, зөвлөлдөх уулзалт, гарын авлагатай тогтмол хөтөлбөр болоод зогсохгүй пара-легал зөвлөхийн хөтөлбөр болох дараагийн шатны зорилтоо дэвшүүлэн ажиллаж байна. Мөн хүүхдийн эрхийг хамгаалах төрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор сургуульд элсэж чадаагүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлаар Хүний эрхийн механизмуудыг дайчлан ажиллахаар баримт нотолгоо бүрдүүлэн, бэлтгэлээ хангаж эхлэв. 2018 онд тус Холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дуу хоолойг бодлого боловсруулагч, олон нийтэд хүргэх шинэ зорилт дэвшүүлсэн ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуулийн талаарх санал бодол, хүсэл мөрөөдөл, тулгарч буй бэрхшээлээ тайлбарлан ярих юм. Ингэхдээ боловсролын бодлого, сургуулийн үйл ажиллагаа, багш, олон нийтийн хандлагатай холбоотой асуудлыг хөндөн өөрсдөө хүргэх арга зүйг судлан, 5 хүүхдийг сурган бэлдэж байна. Арга хэмжээг

ирэх оны ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн өмнө “Хаалгаа нээ” аян нэртэйгээр зохион байгуулахаар төлөвлөж буй. ХБХЭЭХ нь БСШУСЯ-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаарх дэд зөвлөлийн гишүүн болов.

Түгээмэл хөгжил төв ТББ нь байгууллагаа хөгжүүлэх тэтгэлэгт 2016 оноос хамрагдаж, Тэгш хамруулах боловсролын хөтөлбөр бий болгон, бодлогын яриа хэлэлцүүлэгт үр дүнтэй оролцох хүний нөөцөө бэхжүүлэн ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй судлаач, залуучуудаас бүрдэж буй Тэгш хамруулах боловсролын хөтөлбөр нь дунд хугацааны стратегия боловсруулан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд сургахад шаардлагатай тохируулга, тохирох хэрэглэгдэхүүний асуудлаар мэргэших зорилтын хүрээнд мэдлэг, туршлагаа хуримтлуулж, судалгаа, мониторинг, нөлөөллийн ажлаа төлөвлөн хэрэгжүүлж байна. Түгээмэл хөгжил төв ТББ нь тархины саажилттай 20 хүүхдийн жишээн дээр үйлийн хязгаарлалтад суурилсан хандлагаар боловсролын хэрэгцээг тодорхойлох, тохирох хэрэглэгдэхүүнийг сонгох аргачлал боловсруулан, тайлбарлан таниулах сургалтууд хийж эхэллээ. Энэ туршлагадаа үндэслэн тохирох хэрэглэгдэхүүний гарын авлага боловсруулж байгаа болно.

2018 онд ННФ-ын байгуулсан Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ нь сар бүрийн уулзалт, семинараар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад тэгш хамруулах боловсрол, тусгай сургуулийн гүйцэтгэх үүрэг ролийг бусад орны жишээнд түшиглэн судлах, Хөгжлийн бэрхшээлтэй

БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО


хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенцын сурч боловсрох эрх, хүртээмж, үл ялгаварлалтай холбоотой зүйл заалтуудыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн заалтуудтай харьцуулан судлах, сонсголын бэрхшээл, харааны бэрхшээл, аутизм, оюуны бэрхшээлтэй хүүхдийн сурах орчин нөхцөл, багшийн ажлын үнэлгээ, хэлний цөөнх болон сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хос хэлний боловсрол зэрэг асуудлаар мэдээлэл сонсож, хэлэлцэн, өөрсдийн мэдлэгээ гүнзгийрүүлэв. Сүлжээний гишүүн байгууллагуудын арга зүйн дэмжлэг, оролцоотойгоор Монголын Аутизмын холбоо, Дауны холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо зэрэг байгууллагууд олон нийтийн мэдээлэл, боловсролын аян хэрэгжүүлсэн бол Түгээмэл хөгжил төв ТББ нь тархины саажилттай хүүхдийн тохирох хэрэглэгдэхүүн, Хараагүйчүүдийн

үндэсний холбоо нь хараагүй хүүхдийн Брайль үсгийн боловсрол, Сонсголгүйн боловсрол ТББ нь сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хос хэлний боловсролын асуудлаар судалгаанд суурилсан нөлөөллийн ажил төлөвлөн хэрэгжүүллээ. ННФ эдгээр зургаан байгууллагад санхүүгийн болон агуулга, арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллалаа.

Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээ нь энэ жилээс орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжих, тэдний дунд хамтын ажиллагаа бий болгох стратеги хэрэгжүүлж эхэллээ. Сүлжээний 2-3 байгууллагын салбарууд давхцан ажиллаж байгаа 10 аймгийн төлөөлөл болох 50 хүнд 3 өдрийн сургалтаар хөгжлийн бэрхшээлд хандах хүний эрхийн хандлага, сурч боловсрох эрх, тэгш хамруулах боловсрол, тохирох хэрэглэгдэхүүн

“Тэгш хамруулах боловсролын сүлжээ”-ий сургалтын үйл явц. Зүүн гар талаас Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооны Гүйцэтгэх захирал С.Сэлэнгэ, Архангайн Бие даан амьдрах төвийн ажилтан П.Ганчимэг сургалтын үеэр туршлагаа танилцуулж байгаа нь, сургалтад оролцогчид.





ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ

зэрэг агуулгаар мэдээлэл хийж, орон нутагтаа нөлөөлөл хийх, бодлогын хэрэгжилтэд мониторинг хийх зэрэг арга зүйг эзэмшин, орон нутагтаа хамтран хэрэгжүүлэх нөлөөллийн ажлыг төлөвлөх дасгалыг сургалтын үеэр хийж үзлээ. Хууль, үндэсний хөтөлбөр, аймгийн Засаг даргын Мөрийн хөтөлбөр, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэрийн зүйл заалтуудад хүний эрх, тэгш байдлын байр сууринаас шинжилгээ хийж, нөлөөлөл хийх үндэслэл боловсруулах дасгал хийлээ. Ирэх жилийн 3 дугаар улиралд эдгээр байгууллага дахин цугларч, орон нутагтаа хэрэгжүүлсэн нөлөөллийн болон олон нийтийн боловсролын үйл ажиллагааны туршлага, үр дүнгээ нэгтгэн дүгнэж ярилцах юм.

2018 онд эхлүүлсэн нэг томоохон ажил бол багш болохоор суралцаж байгаа МУБИС-ийн оюутнуудад нэгж хичээл дээр сургалтын олон аргыг хослуулан ашиглах, хичээлийн хэвийн явцыг хангах зохион байгуулалт хийх зэрэг аргуудад сургах төсөл юм. Хоёр жилийн

хугацаатай хэрэгжүүлэх энэхүү төслөөр МУБИС-ийн дэргэдэх Боловсролын суурь судалгааны төв нь дидактикийн багш нартай хамтран ялгамжтай сургалтын арга зүй, сурахуйн түгээмэл загвар, анги танхимын менежмент зэрэг хичээлийг боловсруулан, дидактикийн хичээлийн агуулгад интеграцчилж, оюутнуудад эзэмшүүлэх юм.


Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн тэгш оролцооны талаар эерэг ойлголт бүрдүүлэхэд нөлөөлж чадах чухал суваг юм. 2018 онд бид сэтгүүлчдийн энэ чиглэлийн судалгаа, эрэн сурвалжлах сонирхлыг бий болгох зорилгоор уулзалт, семинарууд зохион байгуулахын зэрэгцээ өөрсдийн бэлдсэн багц видеог news.mn сайт дээр байршуулан олон нийтэд хүргэв. Цаашид ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын тэгш оролцооны асуудлаар хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, судлаачдын сонирхлыг бий болгохын зэрэгцээ өөрсдийн бэлдсэн мэдээллийг тараан түгээх суваг болгож дайчлах стратегийг хослуулах болно.



ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ: 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

5 СЕМИНАР, СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- Тэгш хамруулах боловсролын иргэний нийгмийн сүлжээний сар бүрийн уулзалт, семинар
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн “Сурч боловсрох эрх” хэсгийн хэлэлцүүлэг
- “НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц ба үндэсний эрх зүй (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль)-ийн харьцуулалт” хэлэлцүүлэг
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол ба тохирох хэрэглэгдэхүүн” сургалт
- “Тэгш хамруулах боловсролын бодлогын хэрэгжилт, иргэний нийгмийн хяналт” сургалт



ХЭВЛЭН НИЙТЛЭГДСЭН МАТЕРИАЛ

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шүүмж

4 ВИДЕО



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бусдын л адил сонирхол, хүсэл мөрөөдөлтэй, мөн авьяас чадвартай. Гэвч бусад хүүхдэд элдэв асуудалгүй олддог сургуульд сурах боломжийн төлөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд олон саадыг давж, уйгагүй зүтгэх хэрэгтэй болдог. 2018 онд ННФ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чанартай боловсрол эзэмших тэгш эрхийг хамгаалахаар ажиллаж байгаа иргэний нийгмийн байгууллага, эцэг эхчүүдийн холбоодтой хамтран асуудал дэвшүүлсэн цуврал видео бэлтгэн, олон нийтэд хүргэлээ.



- “Тэгш хамруулах боловсрол” цуврал видео <https://news.mn/r/2049719/>



- Аутизм бол бэрхшээл биш <https://news.mn/r/2052139/>



- Сонсголгүй хүүхэд нарийн мэргэжил эзэмшиж чадна <https://news.mn/r/2051639/>



- Н.Тэмүүлэн иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхийг мөрөөддөг <https://news.mn/r/2051063/>




ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Урьдчилан сэргийлэх өндөр үр нөлөөтэй нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Олвеус олон улсын хөтөлбөрийн жишээнд тулгуурлан судалж, Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 10 сургууль “Үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох туршилтын төсөл” хэрэгжүүлж байна.

ННФ нь 2014 оноос өсвөр насны хүүхэд, залуучуудын дундах дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн зан үйлийн шинжлэх ухаанд суурилсан урьдчилан сэргийлэх арга зүйг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа билээ. 2014 оны нөхцөл байдалтай харьцуулахад өнөөдөр үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл нь хүүхэд залуучуудын хөгжил, төлөвшилд урт, богино хугацааны сөрөг нөлөө үзүүлж байгааг хүлээн зөвшөөрч, системтэйгээр урьдчилан сэргийлэх, эрт үед таслан зогсоох хандлага бүрэлдэж эхэлж байна. 2018 онд БСШУСЯ-аас “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого” баримт бичгийг батлан гаргаад байгаа ба үүнд сургууль бүр дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр боловсруулан ажиллаж, гарсан тохиолдол бүрийг мэдээлэхийн зэрэгцээ таслан зогсоох арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгожээ. Уг бодлогын баримт бичиг нь хүүхдүүдийг дээрэлхэлтээс зайлсхийх үнэт зүйлтэй болгож төлөвшүүлэх, эрүүл харилцааны ур чадварт сургах замаар хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой, сургуульд түшиглэсэн үндэсний тогтолцооны эхийг тавьж байгаагаараа онцгой ач холбогдолтой юм.

Үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг нийгмийн бодлогоор дамжуулан урьдчилан сэргийлэх ойлголт хандлага бүрэлдэж

12132132



байгаа энэ үед ННФ нь (i) мэдлэг чадавхыг хөгжүүлж, хамтын ажиллагаагаар тараан түгээх, (ii) идэвх санаачилгатай сургуулиудыг түшиглэн дотоодын туршлагыг бий болгох, (iii) олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлд төвлөрөн ажиллаж байна.

Манай улсад өнөөдөр үе тэнгийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх мэдлэг, чадавхыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдсан хэвээр байна. Бид 2018 онд их дээд сургуулиудтай үргэлжлүүлэн ажиллаж, нийгмийн ажилтан бэлтгэдэг ШУТИС, МУБИС-ийн бакалавр болон магистрын хөтөлбөрт үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх 2-3 кредитийн хичээл бий болгоход дэмжлэг үзүүлэв. Энэ жил мөн Хууль сахиулахын их сургуультай шинээр түншилснээр хууль сахиулахын салбарын боловсон хүчин хүүхэд, залуучуудтай ажиллах мэдлэг, үе тэнгийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх арга зүй эзэмшиж төгсөх юм. Улмаар орон нутагт хүүхэд хамгаалал, хүчирхийллийг

урьдчилан сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж буй цагдаа, сургуулийн болон хорооны нийгмийн ажилтан нь багаар, нэгдсэн ойлголт, арга хандлагаар ажиллах нөхцөл бололцоо бүрдэнэ.

2018 онд уг асуудлаарх мэдлэг, туршлагыг нэгтгэх, хамтын ажиллагаагаар дамжуулан харилцан суралцах боломжийг бий болгох зорилтыг бид чухалчиллаа. Дээрэлхэлтийн эсрэг олон улсын холбооны 2018 оны хуралд Монгол Улсаас хоёр хүн оролцож, сүүлийн үеийн судалгаа, урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл авч, Холбооны гишүүн, зохицуулагч байгууллага, судлаачидтай танилцав. Уг асуудлаар ажиллаж эхэлж байгаа манай орны хувьд үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын мэдлэг, туршлагаас дамжуулан суралцах боломж бий болж байна. Дотоодын судлаачид мөн өөрийн орны туршлагыг нэгтгэх, харилцан суралцах арга хэмжээ зохион байгуулав. МУБИС, ШУТИС санаачлан, ННФ-

12132132



ын дэмжлэгтэйгээр “Үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, энэ чиглэлд бий болж буй мэдлэг, туршлага, санаачилгуудыг нэгтгэх, тараан түгээх, мэдээлэл солилцох арга хэмжээ боллоо. 100 гаруй оролцогчтой уг арга хэмжээнд МУБИС, ШУТИС, Цагдаагийн Ерөнхий Газар, Сонгино-Хайрхан дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо, 3, 7, 72, 97, 52 дугаар сургууль, Шинэ эрин, Шинэ Монгол дунд сургуулийн төлөөлөгчид итгэл тавьж оролцжээ. Онолд суурилсан судалгаа, төрөөс хэрэгжүүлж буй бодлого, сургуулиудын амьд туршлагыг нэг дор хэлэлцэх боломж олгосон энэхүү арга хэмжээг туршлага солилцох, сонирхогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх арга механизм болгож тогтмолжуулах боломжтой.

2018 оны 6-р сард бид салбар дамнасан хамтын ажиллагаа, нэгдсэн ойлголт хандлага бий болгох цугларалт зохион байгууллаа. Хүүхэд хамгаалал, дээрэлхэлт, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх асуудлаар ажиллаж байгаа судлаач багш нар, асуудал хариуцсан төр, захиргааны албан тушаалтан, иргэний нийгмийн байгууллагынхан, ЕБС болон хорооны нийгмийн ажилтан зэрэг 50 орчим хүн хоёр өдрийн туршид дээрэлхэлтийн мөн чанар, түүнийг урьдчилан сэргийлэх арга хандлага, туршлагауудыг судлан, МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн багш нараас мэдлэг, арга зүйн мэдээлэл авлаа.

Олон улсын туршлагаар, хүчирхийллийг урьдчилан сэргийлэх гол стратеги бол сургуульд суурилсан амьдрах ухаан, нийгмийн харилцааны ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрүүд

байна. Урьдчилан сэргийлэх өндөр үр нөлөөтэй болох нь олон удаагийн үнэлгээгээр батлагдсан Олвеус олон улсын хөтөлбөр, Финландын Кива хөтөлбөр зэрэг нь сургууль албан ёсоор дүрэм журмаа баталж, түүнд урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр, мөн гарсан тохиолдолд эрт үед таслан зогсоох тогтолцоогоо тусган, үүрэг хариуцлагыг албан ёсоор оноож өгдөг онцлогтой. Уг загварын дагуу Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 10 сургууль “Үе тэнгийн дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох туршилтын төсөл” хэрэгжүүлж байгаа ба үүнд ННФ, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг (БХАН), Боловсролын зөвлөгөө мэдээллийн төв (БЗМТ) зэрэг төрийн бус байгууллагууд тусалж байна. Төслийн хүрээнд сургуулиуд дээрэлхэлтийн эсрэг журам баталж, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, сурагчдад амьдрах ухаан, эерэг харилцааны ур чадвар олгох сургалтууд хийхийн зэрэгцээ сурагчдыг оролцуулан сургуулийн орчны аюултай цэгийн зураглал гарган хяналт тавих, сурагчдын дунд үе тэнгийн дээрэлхэлтийн нөхцөл байдлыг тандах судалгаа авах зэрэг арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байна. БХАН нь сурагчдад хүргэх агуулгыг модульчлан боловсруулж, нийгмийн ажилтан, анги даасан багш нарыг сургаж байгаа бол БЗМТ нь захирлуудтай ажиллаж, журам боловсруулах, нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэгт төвлөрч байна. Төсөлд Налайх дүүргийн Голомт цогцолбор сургууль, Баянзүрх дүүргийн 85, 13 дугаар сургууль, Чингэлтэй дүүргийн 72, 23 дугаар сургууль, Сонгино Хайрхан дүүргийн 9, 65 дугаар сургууль, Хан Уул дүүргийн 52, 60 дугаар сургууль, Сүхбаатар дүүргийн 35 дугаар сургууль оролцож байгаа ба эдгээр 10 сургууль

ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

БСШУСЯ-аас баталсан Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх бодит туршлагыг бий болгож байна.

Тэрчлэн, олон нийтэд үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, цахим дээрэлхэлтийг ойлгуулж, урьдчилан сэргийлэх хандлага төлөвшүүлэх зорилтын хүрээнд ННФ нь yolo.mn сайттай хамтран мэдээллийн аян хэрэгжүүлэв. Бид мөн залуучуудын идэвхтэй оролцоог хангасан кампанит ажлын нэг арга хэлбэр болгож Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хакатон зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь тодорхой нэг бүтээл шалгаруулах уламжлалт хакатоноос

ялгаатай бөгөөд залуучуудын оролцоотойгоор асуудлыг судлах арга хандлагаар зохион байгуулагдсан юм. Хоёр өдрийн уг арга хэмжээнд оюутан, сурагч, иргэний нийгмийн идэвхтэн 50 залуус оролцож, их дээд сургуулийн багш нар, иргэний нийгмийн судлаачдын дэмжлэгтэйгээр уг асуудлаар мэдээлэл судалж, бүтээл боловсруулж ажиллалаа. Хакатоны үр дүнд үе тэнгийн дээрэлхэлт, түүнийг урьдчилан сэргийлэх асуудлыг судлах хөлөгт тоглоом, мэдээлэл хүргэх вэб сайт хийх төслийн санаа гаргасан багуудад боловсруулалт хийх дэмжлэгийг үргэлжлүүлэн үзүүлж байна.

12132132



ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЭЛ, ДЭЭРЭЛХЭЛТИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ: 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

3 СЕМИНАР, СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- Салбар дамнасан 2 өдрийн сургалт цугларалт
- Үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг хакатон -2018
- Туршлага бий болгох төслийн 10 сургуулийн Захирлуудын семинар, хэлэлцүүлэг

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД

- “Нээлттэй Нийгэм Форум”-ынхон дээрэлхэлтийн эсрэг залуусын дуу хоолойг нэгтгэлээ – нийтлэл /Өнөөдөр сонин, 2018 оны 11 сарын 27/
- Хүүхдүүд нэгнийгээ дээрэлхэх, дээрэлхүүлэх нь байдаг л юм гэж та боддог уу? ярилцлага <http://news.gogo.mn/r/233855>
- Олон нийтэд үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл, цахим дээрэлхэлтийг ойлгуулж, урьдчилан сэргийлэх “ХАКАТОН-2018” арга хэмжээний үеэрх сурвалжилга - /МҮОНРТ/ https://www.youtube.com/watch?v=TX9dYa3_Ncc&fbclid=IwAR1bQl6pwO2CAFYz31SfdQwT9dqIUjXGiyhT9TbjX7XILA3NEAYc_fZhpks

ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

- Үе тэнгийнхний дундах гадуурхалт, дээрэлхэлт бол залуус бидний сонголт БИШ видео шторк <https://bit.ly/2lReHVR>
- Үе тэнгийн дээрэлхэлтийн талаар залуучуудад зориулсан мэдээллийн хуудас
- Үе тэнгийн дээрэлхэлтийн талаар эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн хуудас



Нээлттэй Нийгэм Форум 2018 онд нийт 1,843,800 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс \$ 1,770,000 Нээлттэй Нийгэм Хүрээлэн болон Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, \$ 21,600 LOGIN, \$ 42,000 IDEA; \$8,000 UPR info; \$2,200 бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг дор хүснэгтээр харуулав.

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Тэтгэлгийн зардал	Үйл ажиллагааны зардал	Нийт зардал
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ			
Төрийн хариуцлагын механизмуудыг бэхжүүлэх	91,199	57,538	148,737
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох	62,747	91,479	154,226
Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах	98,293	84,708	183,002
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих	59,531	76,109	135,640
			-
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ			
Хүний эрх	12,037	85,947	97,984
Эрүүгийн эрх зүй, хууль сахиулах салбарын шинэтгэлийн дэмжих	50,386	95,903	146,289
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх	51,364	57,083	108,448
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх	131,777	82,176	213,953
			-
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО			
Тэгш хамруулах боловсрол	56,466	58,237	114,703
Залуучуудын дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх	66,320	44,299	110,619
			-
ЗАХИРГАА	395,416	395,416	
			-
НИЙТ ДҮН	680,120	1,128,898	1,809,018

НИЙТ ЗАРЦУУЛАЛТ

\$ доллар

Хөтөлбөр	Байгууллагад олгосон тэтгэлэг	Хувь хүнд олгосон тэтгэлэг	Тэтгэлгийн нийт зардал
АРДЧИЛСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ			
Төрийн хариуцлагын механизмуудыг бэхжүүлэх	6,493	84,706	91,199
Сонгуулийн үйл явц, улс төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох	51,242	11,505	62,747
Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах	-	98,293	98,293
Эрдэс баялгийн салбарын сайн засаглалыг дэмжих	6,931	52,600	59,531
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ДЭМЖИХ			
Хүний эрх	-	12,037	12,037
Эрүүгийн эрх зүй, хууль сахиулах салбарын шинэтгэлийн дэмжих	-	50,386	50,386
Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх	9,857	41,508	51,364
Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх	41,861	89,916	131,777
БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН БОДЛОГО			
Тэгш хамруулах боловсрол	-	56,466	56,466
Залуучуудын дундах хүчирхийлэл, дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх	7,306	59,014	66,320
ЗАХИРГАА			
НИЙТ ДҮН	123,689	556,431	680,120

2018 ОНД ОЛГОСОН ТЭТГЭЛГИЙН ЖАГСААЛТ

\$ доллар

Д/д	Байршил	Тэтгэлэг авсан байгууллага, хувь хүн	Төрөл	Тэтгэлгийн дүн
1	Улаанбаатар	Глоб интернэшнл	ТББ	\$ 45,000
2	Улаанбаатар	Монголын боловсролын их сургууль	Сургууль	\$ 41,000
3	Улаанбаатар	Үнэн хатамж	ТББ	\$ 36,792
4	Улаанбаатар	Хууль зүйн үндэсний хүрээлэн	Төрийн	\$ 33,597
5	Улаанбаатар	Хууль сахиулахын их сургууль	Сургууль	\$ 25,000
6	Улаанбаатар	Оюуны инновац	ТББ	\$ 18,954
7	Улаанбаатар	Монголын хуульчдын холбоо	ТББ	\$ 15,008
8	Улаанбаатар	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг	ТББ	\$ 14,428
9	Улаанбаатар	Хөөрхөн зүрхнүүдийн аян	ТББ	\$ 11,277
10	Улаанбаатар	Хууль зүйн туслалцааны төв	Төрийн	\$ 10,427
11	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	\$ 10,364
12	Улаанбаатар	Монголын криминологичдын холбоо	ТББ	\$ 9,703
13	Улаанбаатар	Монголын криминологичдын холбоо	ТББ	\$ 9,103
14	Улаанбаатар	Түгээмэл эрх-хөгжил төв	ТББ	\$ 8,860
15	Улаанбаатар	Гүнж төв	ТББ	\$ 7,683
16	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$ 7,623
17	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$ 7,546
18	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ	\$ 7,523
19	Улаанбаатар	Монголын хуульчдын холбоо	ТББ	\$ 7,430
20	Улаанбаатар	Боловсролын зөвлөгөө, мэдээллийн төв	ТББ	\$ 6,811
21	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ	\$ 6,180
22	Улаанбаатар	Б.Төгсцэнгэл	Иргэн	\$ 6,100
23	Улаанбаатар	Ч.Ариунхур	Иргэн	\$ 6,100
24	Улаанбаатар	С.Бямбацогт	Иргэн	\$ 6,100
25	Улаанбаатар	С.Эрдэнэ	Иргэн	\$ 6,100

26	Улаанбаатар	С.Оюунбилэг	Иргэн	\$	6,100
27	Улаанбаатар	Б.Пүрэвдорж	Иргэн	\$	6,100
28	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$	6,000
29	Улаанбаатар	Баяр мэдээллийн боловсрол	ТББ	\$	5,900
30	Улаанбаатар	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	\$	5,840
31	Улаанбаатар	Их бага Баян шарга сан	ТББ	\$	5,146
32	Ховд	Ховдын толь сонин	ТББ	\$	4,676
33	Өмнөговь	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	4,589
34	Улаанбаатар	Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төсөл	ТББ	\$	4,500
35	Улаанбаатар	ЛГБТ	ТББ	\$	4,462
36	Баян-Өлгий	Нийгмийн хөгжлийг дэмжих холбоо	ТББ	\$	4,455
37	Улаанбаатар	Байгаль орчны эко сэтгүүлчдийн сүлжээ	ТББ	\$	4,275
38	Архангай	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	\$	4,218
39	Улаанбаатар	Глоб интернэшнл	ТББ	\$	4,095
40	Улаанбаатар	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	4,079
41	Улаанбаатар	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо	ТББ	\$	3,950
42	Увс	Монголын байгаль эхийн аврал сан	ТББ	\$	3,528
43	Улаанбаатар	Дэмо крейзи залуусын төв	ТББ	\$	3,457
44	Улаанбаатар	Сонсголгүйн боловсрол	ТББ	\$	3,456
45	Улаанбаатар	“Шинэ эвлэл” орон нутгийн сэтгүүлчдийн холбоо	ТББ	\$	3,373
46	Улаанбаатар	Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	\$	3,190
47	Улаанбаатар	М.Нямдорж	Иргэн	\$	2,985
48	Улаанбаатар	Б.Баянмөнх	Иргэн	\$	2,973
49	Улаанбаатар	А.Амарсанаа	Иргэн	\$	2,973
50	Улаанбаатар	С.Гэрэлмаа	Иргэн	\$	2,943
51	Улаанбаатар	Д.Саямаа	Иргэн	\$	2,895

52	Улаанбаатар	Оюу-толгойн хяналт	ТББ	\$	2,840
53	Улаанбаатар	Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо	ТББ	\$	2,794
54	Улаанбаатар	Б.Даваатогтох	Иргэн	\$	2,743
55	Улаанбаатар	М.Амарбаяр	Иргэн	\$	2,741
56	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$	2,655
57	Завхан	Таны эрх, эгэл нандин	ТББ	\$	2,588
58	Улаанбаатар	ЭТББСүлжээний төв	ТББ	\$	2,567
59	Улаанбаатар	Б.Уранцэцэг	Иргэн	\$	2,507
60	Улаанбаатар	Г.Билгүүн	Иргэн	\$	2,505
61	Өвөрхангай	ЛЭОС, Өвөрхангай аймаг	ТББ	\$	2,473
62	Улаанбаатар	Л.Амгаланбаяр	Иргэн	\$	2,450
63	Улаанбаатар	Т.Нармандах	Иргэн	\$	2,440
64	Улаанбаатар	Ж.Хунан	Иргэн	\$	2,430
65	Дундговь	Дундговь аймгийн Сургалт, судалгаа, хөгжлийн төв	ТББ	\$	2,428
66	Улаанбаатар	Чингэлтэй дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо	ТББ	\$	2,389
67	Орхон	Эрдэнэт хүмүүний Эв нэгдэл	ТББ	\$	2,352
68	Өвөрхангай	ЛЭОС, Өвөрхангай аймаг	ТББ	\$	2,338
69	Улаанбаатар	Т.Уранболор	Иргэн	\$	2,317
70	Улаанбаатар	Д.Мөнхтуяа	Иргэн	\$	2,311
71	Улаанбаатар	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	\$	2,309
72	Завхан	Өрнөх хөгжил	ТББ	\$	2,305
73	Улаанбаатар	Хүртээмжтэй хөгжил хүрээлэн	ТББ	\$	2,294
74	Улаанбаатар	Үнэн хатамж	ТББ	\$	2,279
75	Улаанбаатар	Г.Саранзаяа	Иргэн	\$	2,276
76	Булган	Булганы өнгө	ТББ	\$	2,269
77	Улаанбаатар	С.Оюунбилэг	Иргэн	\$	2,235

78	Улаанбаатар	Э.Гэрэлт-Од	Иргэн	\$	2,235
79	Баянхонгор	Амьд хууль	ТББ	\$	2,230
80	Төв	Төв аймгийн Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$	2,197
81	Дархан-Уул	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	2,186
82	Улаанбаатар	П.Амаржаргал	Иргэн	\$	2,181
83	Улаанбаатар	Б.Ивээл	Иргэн	\$	2,181
84	Улаанбаатар	Б.Эрдэнэсанаа	Иргэн	\$	2,181
85	Дархан-Уул	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	2,013
86	Улаанбаатар	Г.Билгүүн	Иргэн	\$	2,000
87	Улаанбаатар	Г.Саранзаяа	Иргэн	\$	2,000
88	Улаанбаатар	Д.Мөнхтуяа	Иргэн	\$	2,000
89	Улаанбаатар	Түгээмэл-эрх хөгжил төв	ТББ	\$	1,975
90	Улаанбаатар	Онч шийдэл	ТББ	\$	1,964
91	Улаанбаатар	Эрх зүйн хөгжлийн төлөө	ТББ	\$	1,961
92	Улаанбаатар	Оюуны инновац	ТББ	\$	1,957
93	Улаанбаатар	Ж.Хунан	Иргэн	\$	1,950
94	Улаанбаатар	Г.Бат-Отгон	Иргэн	\$	1,950
95	Улаанбаатар	Д.Пүрэвбаатар	Иргэн	\$	1,950
96	Улаанбаатар	М.Мөнхжаргал	Иргэн	\$	1,950
97	Улаанбаатар	Төсвийн удирдлагын хүрээлэн	ТББ	\$	1,896
98	Улаанбаатар	Д.Баттулга	Иргэн	\$	1,872
99	Улаанбаатар	Мэдэх эрх	ТББ	\$	1,869
100	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$	1,847
101	Улаанбаатар	Зүүн бүсийн хүний эрхийн төв	ТББ	\$	1,840
102	Улаанбаатар	Эрх зүйн соёл	ТББ	\$	1,827
103	Улаанбаатар	Л.Отгонцэцэг	Иргэн	\$	1,818
104	Багануур	Залуус манлайлал төв	ТББ	\$	1,802
105	Улаанбаатар	Эрх зүйн соёл	ТББ	\$	1,768
106	Улаанбаатар	Ц.Мандхайхатан	Иргэн	\$	1,745

107	Дархан-Уул	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	1,745
108	Дорнод	УТБАкадеми Дорнод салбар	ТББ	\$	1,725
109	Баянхонгор	Амартайван итгэл	ТББ	\$	1,696
110	Улаанбаатар	Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн	ТББ	\$	1,635
111	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	\$	1,630
112	Говьсүмбэр	Хөгжлийн түншлэл	ТББ	\$	1,624
113	Улаанбаатар	Н.Норовсамбуу	Иргэн	\$	1,613
114	Улаанбаатар	Г.Төрмөнх	Иргэн	\$	1,575
115	Хөвсгөл	Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо	ТББ	\$	1,522
116	Дундговь	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	1,519
117	Говь-Алтай	Говь-Алтай аймгийн ИТХ	Төрийн	\$	1,454
118	Улаанбаатар	Ч.Цагаанхүү	Иргэн	\$	1,400
119	Улаанбаатар	Н.Отгончимэг	Иргэн	\$	1,367
120	Улаанбаатар	Б.Буянхишиг	Иргэн	\$	1,367
121	Улаанбаатар	Б.Мөнхтогтох	Иргэн	\$	1,348
122	Улаанбаатар	Байгаль орчны эко сэтгүүлчдийн сүлжээ	ТББ	\$	1,327
123	Улаанбаатар	А.Энхбат	Иргэн	\$	1,315
124	Улаанбаатар	Б.Мөнх-Очир	Иргэн	\$	1,315
125	Улаанбаатар	С.Энхцэцэг	Иргэн	\$	1,295
126	Төв	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	1,275
127	Улаанбаатар	Гурав, арван нэг сэтгүүлчдийн клуб	ТББ	\$	1,269
128	Улаанбаатар	Экологи Өв соёл нийгэмлэг	ТББ	\$	1,262
129	Сэлэнгэ	Ноён хайрхан	ТББ	\$	1,184
130	Төв	Төв аймгийн ИТХ	ТББ	\$	1,179
131	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$	1,179
132	Улаанбаатар	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо	ТББ	\$	1,139
133	Улаанбаатар	Монголын дауны холбоо	ТББ	\$	1,139

134	Улаанбаатар	Монголын аутизмын холбоо	ТББ	\$	1,139
135	Улаанбаатар	Т.Саруул	Иргэн	\$	1,088
136	Өвөрхангай	Оновчтой хөгжил	ТББ	\$	961
137	Өвөрхангай	Сайн засаглал, тогтвортой хөгжил	ТББ	\$	943
138	Улаанбаатар	Н.Норовсамбуу	Иргэн	\$	827
139	Улаанбаатар	Р.Пүрэвбаатар	Иргэн	\$	827
140	Орхон	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг	ТББ	\$	796
141	Увс	Гэргий ухаан	ТББ	\$	796
142	Хэнтий	Монголын скаутын холбоо	ТББ	\$	796
143	Говьсүмбэр	Хотол чойр	ТББ	\$	794
144	Орхон	Орхон 21-р зуун	ТББ	\$	787
145	Говь-Алтай	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөл	ТББ	\$	763
146	Завхан	Таны эрх, эгэл нандин	ТББ	\$	763
147	Улаанбаатар	Г.Алтангэрэл	Иргэн	\$	761
148	Баянхонгор	Баянхонгор аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо	ТББ	\$	758
149	Дундговь	Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан	ТББ	\$	758
150	Өвөрхангай	Орон нутгийн сургалт судалгааны хөгжлийн агентлаг	ТББ	\$	758
151	Өмнөговь	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	758
152	Төв	Төв аймгийн Ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$	758
153	Ховд	Хэвлэлийн хүрээлэн-Ховд, баруун бүс	ТББ	\$	758
154	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$	752
155	Улаанбаатар	Сэтгэлзүйн мэдрэмж	ТББ	\$	749
156	Булган	Булганы мэдээ сонин	ТББ	\$	733

157	Баян-Өлгий	Баян-Өлгий аймгийн ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$	703
158	Улаанбаатар	С.Шинэгэрэл	Иргэн	\$	664
159	Улаанбаатар	Ч.Соёл-Ундрах	Иргэн	\$	592
160	Булган	Гэрэлт ирээдүйн оршихуй	ТББ	\$	587
161	Өвөрхангай	Эх нутаг хөгжил төв	ТББ	\$	577
162	Дархан-Уул	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Дархан салбар	ТББ	\$	575
163	Өмнөговь	Өсвөр үе ирээдүй Увс төв	ТББ	\$	557
164	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн Ажил олгогч эздийн холбоо "Сэлэнгэ-Итгэл"	ТББ	\$	552
165	Хөвсгөл	Сүүн тахилт	ТББ	\$	482
166	Өмнөговь	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	470
167	Орхон	Төр-иргэн түншлэл	ТББ	\$	466
168	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн Ажил олгогч эздийн холбоо "Сэлэнгэ-Итгэл"	ТББ	\$	443
169	Завхан	Завхан аймгийн ахмад мэргэжилтний холбоо	ТББ	\$	431
170	Хэнтий	Хэнтий аймгийн ажил олгогч эздийн холбоо	ТББ	\$	423
171	Улаанбаатар	Түгээмэл-эрх хөгжил төв	ТББ	\$	380
172	Улаанбаатар	Оюуны инновац	ТББ	\$	380
173	Улаанбаатар	ЛГБТ	ТББ	\$	380
174	Улаанбаатар	Гүнж төв	ТББ	\$	380
175	Улаанбаатар	Хөөрхөн зүрхнүүдийн аян	ТББ	\$	380
176	Улаанбаатар	Хөвсгөл далайн эзэд хөдөлгөөн	ТББ	\$	380
177	Улаанбаатар	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	ТББ	\$	380
178	Улаанбаатар	Монфемнет үндэсний сүлжээ	ТББ	\$	380
179	Улаанбаатар	Оюу-толгойн хяналт	ТББ	\$	380
180	Улаанбаатар	Хил хязгааргүй алхам	ТББ	\$	380

181	Улаанбаатар	Хүйсийн тэгш эрх төв	ТББ	\$	380
182	Улаанбаатар	Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо	ТББ	\$	380
183	Улаанбаатар	Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо	ТББ	\$	380
184	Улаанбаатар	Сонсголгүйн боловсрол	ТББ	\$	380
185	Улаанбаатар	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо	ТББ	\$	380
186	Улаанбаатар	Монголын дауны холбоо	ТББ	\$	380
187	Өмнөговь	Өмнөговь аймгийн бие даан амьдрах төв	ТББ	\$	380
188	Архангай	Архангай аймгийн бие даан амьдрах төв	ТББ	\$	380
189	Улаанбаатар	Дэмо крейзи залуусын төв	ТББ	\$	380
190	Улаанбаатар	Өөрчлөлтийн салхи	ТББ	\$	380
191	Улаанбаатар	Монголын аутизмын холбоо	ТББ	\$	380
192	Булган	Булганы өнгө	ТББ	\$	380
193	Улаанбаатар	Үнэн хатамж	ТББ	\$	380
194	Өвөрхангай	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	ТББ	\$	380
195	Улаанбаатар	Захиргааны шинэ санаачилга	ТББ	\$	380
196	Багануур	Залуус манлайлал төв	ТББ	\$	380
197	Ховд	Ховдын толь сонин	ТББ	\$	380
198	Баян-Өлгий	Нийгмийн хөгжлийг дэмжих холбоо	ТББ	\$	380
199	Хөвсгөл	Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо	ТББ	\$	380
200	Улаанбаатар	Хэрэглэгч сан	ТББ	\$	380
201	Баянхонгор	Амьд хууль	ТББ	\$	380
202	Улаанбаатар	Бодлогод залуусын хяналт	ТББ	\$	380
203	Улаанбаатар	Оновчтой хөгжил	ТББ	\$	380
204	Улаанбаатар	Өөрчлөлтийн төлөөх залуу эмэгтэйчүүд	ТББ	\$	380
205	Улаанбаатар	Сонгогчдын боловсрол төв	ТББ	\$	380
206	Улаанбаатар	Хүний эрх хөгжил төв	ТББ	\$	380

207	Улаанбаатар	Байгаль орчны эко сэтгүүлчдийн сүлжээ	ТББ	\$	380
208	Төв	Бугат Заамар, Бургаст Туул	ТББ	\$	380
209	Улаанбаатар	Буйр нуур, Халх гол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн	ТББ	\$	380
210	Улаанбаатар	Их бага Баян шарга сан	ТББ	\$	380
211	Улаанбаатар	Монголын байгаль эхийн аврал сан	ТББ	\$	380
212	Баянхонгор	Хонгор нутгийн дуудлага	ТББ	\$	380
213	Улаанбаатар	Монголын байгаль орчныг хамгаалах холбоо	ТББ	\$	380
214	Улаанбаатар	Өрнөх хөгжил	ТББ	\$	380
215	Улаанбаатар	Сонгино бие даан амьдрах төв	ТББ	\$	380
216	Улаанбаатар	Тува ээж	ТББ	\$	380
217	Улаанбаатар	Байгаль орчны төлөөх хуульчдын холбоо	ТББ	\$	380
218	Улаанбаатар	Хэрэглэгчийн сэтгэл судлалын хүрээлэн	ТББ	\$	380
219	Улаанбаатар	Транспэрэнси Интернэшнл Монгол	ТББ	\$	380
220	Улаанбаатар	Гэр иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв	ТББ	\$	380
221	Дорнод	Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн	ТББ	\$	333
222	Сэлэнгэ	Сэлэнгэ аймгийн Ажил олгогч эздийн холбоо "Сэлэнгэ-Итгэл"	ТББ	\$	288
НИЙТ				\$	680,120

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД, АЖИЛТНУУД

Нээлттэй Нийгэм Форумын Удирдах Зөвлөлийн гишүүд

Г. Уранцоож	УЗ-ийн дарга, Хүний эрх хөгжил төвийн тэргүүн
Ж. Үнэнбат	УЗ-ийн гишүүн, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ-ын гүйцэтгэх захирал
Ч. Хашчулуун	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ЭЗС-ийн багш
Ч. Лодойравсал	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ХШУИС-ийн багш
О. Энхтуяа	УЗ-ийн гишүүн, Дэ Нэйчэр консерванси ТББ-ын захирал
П. Наранбаяр	УЗ-ийн гишүүн, Шинэ Монгол дунд сургуулийн захирал
О. Мөнхсайхан	УЗ-ийн гишүүн, МУИС-ийн ХЗС-ийн багш

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

П. Эрдэнэжаргал jargal@forum.mn

Нээлттэй Нийгэм Форумын ажилтнууд

П. Бадамрагчаа	Эрх зүйн хөтөлбөрийн менежер	badmaa@forum.mn
А. Гэрэлмаа	Боловсрол, Нийгмийн бодлогын хөтөлбөрийн менежер	gerelmaa@forum.mn
Д. Оюунбадам	Засаглалын хөтөлбөрийн менежер	oyunbadam@forum.mn
Б. Хишигсайхан	Эрх зүйн хөтөлбөрийн менежер	khishgee@forum.mn
Д. Энхцэцэг	Засаглалын хөтөлбөрийн менежер	enhee@forum.mn
Д. Эрдэнэчимэг	Засаглалын хөтөлбөрийн менежер	chimgee@forum.mn
О. Сэлэнгэ	Хөтөлбөрийн туслах ажилтан	selenge@forum.mn
У. Энхцэцэг	Хөтөлбөрийн туслах ажилтан (2018 оны 9 сар хүртэл)	enkhtsetseg@forum.mn
Б. Үүрийнтуяа	Хөтөлбөрийн туслах ажилтан	fellowship@forum.mn
Д. Балжид	Мэдээллийн менежер	baljid@forum.mn
Б. Мөнхгэрэл	Мэдээллийн ажилтан	munkhgerel@forum.mn
Д. Жавхлан	Санхүүгийн захирал	javkhlan@forum.mn
Ж.Алтанчимэг	Нягтлан бодогч, тэтгэлгийн менежер	altanchimeg@forum.mn
Э. Сайнтүвшин	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	sainaa@forum.mn
Б. Амгалан	Захиргааны ажилтан	osf@forum.mn
Б. Баатар	Захиргааны туслах ажилтан	baatar@forum.mn
Г. Цэдэвхүү	Захиргааны туслах ажилтан	tsedev@forum.mn
Б.Бат-Эвлэл	Захиргааны туслах ажилтан	

Нийтлэг И-мэйл: osf@forum.mn
